

Mongolian Economy

2026 ОНЫ 05 САР (204)

www.mongolianeconomy.mn

Онцлох ярилцлага

Нийслэлийн усны салбарын шинэчлэл
2030 он хүртэл үргэлжилнэ

Төсөл

Өнгөрсөн, одоо, ирээдүйг
“аварсан” мега төсөл



УЛААНБААТАР ХОТ УСНЫ ТУСГААР ТОГТНОЛОО БАТАЛГААЖУУЛАВ



АНУ, Монгол Улсын татвар төлөгчдийн мөнгөөр
бүтээн байгуулсан УСНЫ КОМПАКТ төсөл

АНУ-ЫН АРД ТҮМНИЙ ТАТВАРААР БОССОН ЦОГЦ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ МОНГОЛД

АНУ болон Монголын татвар төлөгчдөд баярлалаа





Н.Энхбаяр
Орлогч эрхлэгч

УСНЫ КОМПАКТ ХӨТӨЛБӨР ЦЭНХЭР АЛТНЫ УНДАРГА

Хүн төрөлхтөнд заяасан хамгийн үнэт баялаг бол бидний өдөр тутамдаа үл анзааран хэрэглэдэг ус юм. Ялангуяа Туулын хөндийд аж төрж буй бидэнд дэлхийн олон хотод тэр бүр заяагаагүй ариун тансаг ус ногджээ. Ийн хэлж буй шалтгаан нь Улаанбаатар хотын унд, ахуйн хэрэглээ бараг бүхэлдээ гүний цэнгэг усанд түшиглэдэгтэй холбоотой.

Өдгөө маш олон улс үндэстэн далайн усаа давсгүйжүүлж, хэдэн зуун километрийн алсаас ус татан, аварга том далан, усан сан байгуулж байж хэрэглээгээ шийдэж байна. Харин бид гадаргын бохирдлоос харьцангуй хамгаалагдсан гүний цэнгэг усыг өдөр тутмын амьдралдаа ашиглаж байгаа нь үнэндээ том хувь заяа, том аз юм. Гэхдээ энэ их азтайгаа дүйх үүрэг хариуцлагыг бид үүрд мөнх үүрч явах учиртай. Туулын хөндий, газар доорх усны эх үүсвэрүүдээ хайрлахгүйгээр Улаанбаатарын ирээдүйг хамгаална гэж ярих боломжгүй.

Харин өнөөдөр бид АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн Усны компакт хөтөлбөрийн хүрээнд ирээдүйгээ илүү тайвнаар зураглах боломж бүрдээд байна. Компактын хүрээнд, Шувуун фабрик, Биокомбинатын орчимд баруун эх үүсвэрийг шинээр нээснээр жил тутам 50 сая тонн цэнхэр алт олборлох боломж бүрдсэн.

Мөн Ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд 18 сая тонн буюу Буйр нуурын усыг дөрөв нугалсантай тэнцэх хэмжээний усыг дахин боловсруулж, энэ хэмжээний гүний ус хэмнэх нөхцөл бүрдлээ. Энэ үйлдвэрийн ачаар Төв цэвэрлэх байгууламжаас Туул гол руу нийлүүлдэг дутуу цэвэрлэсэн усны хэмжээ дээр дурдсан хэмжээгээр татарна. Үүгээр барахгүй ДЦС-3, ДЦС-4 зэрэг томоохон станцууд техникийн хэрэглээндээ гүний цэвэршүүлсэн усыг бус, дахин боловсруулсан ус ашигладаг болж байна.

Одоо хамгийн чухал нь хамгаалагдсан ирээдүйгээ хайрлах. Усаа хайрлана гэдэг ирээдүйгээ хайрлахын нэр юм. ■

Эрүүл сэтгүүл зүй

Mongolian¹⁵
Economy

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр (9999 4248)

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

Н.Энхбаяр (9916 1303)

РЕДАКТОР:

Т.Амаржаргал

MONGOLIANECONOMY.MN

ВЭБ САЙТЫН РЕДАКТОР:

Б.Шүрэнчимэг

СЭПҮҮЛЧИД:

У.Сарангэрэл

Р.Ренчиндулам

Б.Даваажав

У.Анхцэцэг

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗАР:

БИЗНЕС ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ДАРГА

Б.Амарсайхан (9997 1391)

БИЗНЕС ХАРИЛЦААНЫ МЕНЕЖЕР

Ж.Оюунтөгс (9997 1392)

Т.Төгсжаргалант (9914 5541)

ДИЖИТАЛ МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР

Т.Түвшинжаргал (9509 0223)

ХАЯГ:

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө,
Express Tower 801

УТАС:

7011-1125 | 7011-1126

ISSN 2664-195X

E-MAIL: info@mongolianeconomy.mn

FACEBOOK: Mongolian Economy

TWITTER: EconomyMongolia



03 РЕДАКЦИЙН ЗУРВАС

Усны компакт хөтөлбөр
Цэнхэр алтны ундарга

05 МЭНДЧИЛГЭЭ

Усны Компактыг Монгол, Америк улс хамтран
амжилттай хэрэгжүүлсэнд баяртай байна

06 ОНЦЛОХ НИЙТЛЭЛ

Улаанбаатар хот усны тусгаар
тогтнолоо баталгаажуулав

08 БАЙР СУУРЬ

Хоёр улсын хамтдаа хийж бүтээсэн
бүхнээр бид бахархаж байна

09 БАЙР СУУРЬ

Эдийн засгийн өсөлтийн түншүүд болох
шинэ үе шат руу орж байна

10 ОНЦЛОХ ЯРИЛЦЛАГА

Нийслэлийн усны салбарын шинэчлэл
2030 он хүртэл үргэлжилнэ

14 ШИЙДЭЛ

Хотыг аварсан холын
хүмүүст баярлалаа

18 БАЙР СУУРЬ

26 УСУГ

Компакт гэрээ усны салбарт менежментийн
шинэ арга барил, стандарт авчирлаа

28 ТӨСӨЛ

Өнгөрсөн, одоо, ирээдүйг
“аварсан” мега төсөл

30 УС ХАНГАМЖ

Алтан тэвшийн хөндийнхний
амьдралын чанар сайжирна

32 ХАЯГДАЛ УС

Хаягдал усыг “чандмань эрдэнэ”
болгосон хамтын шийдэл

34 ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Усны компакт
хөтөлбөрийн тархи

УСНЫ КОМПАКТЫГ **МОНГОЛ, АМЕРИК УЛС** ХАМТРАН АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭНД БАЯРТАЙ БАЙНА



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

Монгол Улсын тогтвортой хөгжлийн түүхэнд онцгой ач холбогдол бүхий Усны Компакт хөтөлбөр амжилттай хэрэгжиж, томоохон үйлдвэрүүд үүд хаалгаа нээж байгаа түүхэн үйл явдлыг тохиолдуулан “Монголиан экономи” сэтгүүлийн уншигч Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

АНУ-ын Мянганы сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар Усны Компакт гэрээг хэрэгжүүлснээр Улаанбаатар хотын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэж байгааг эрхэм уншигчдад дуулгахад таатай байна.

Хүн төрөлхтний амьдралын эх булаг болсон усны нөөцөө хамгаалах, ирээдүй хойчдоо цэвэр тунгалаг усны эх үүсвэрийг өвлүүлэн үлдээх бидний алсын хараа өнөөдөр бодит бүтээн байгуулалт болж “Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр” болон “Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр” сүндэрлэн бослоо.

Одоогоос найман жилийн өмнө буюу 2018 онд миний бие АНУ-ын Мянганы сорилтын корпорацтай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурж, Мянганы сорилтын хоёрдугаар Компакт гэрээг хэрэгжүүлэхээр 2021 онд бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж байсан бол өнөөдөр ийнхүү бодит ажил болж, үүд хаалгаа нээж байгаад туйлын баяртай байна.

Энэ бол Монгол Улсын тогтвортой хөгжил, ард иргэдийн маань ая тухтай амьдралыг баталгаажуулах, нийслэл Улаанбаатар хотын өргөжин тэлэх суурь нөхцөлийг бүрдүүлж буйг илэрхийлэх түүхэн ач холбогдолтой үйл явдал юм.

Сонгинохайрхан уулын зүүн бэлд байгуулсан ус хангамжийн Баруун эх үүсвэр Улаанбаатар хотын ус хангамжийг жилд 50 сая шоо метр хүртэл хэмжээгээр нэмэгдүүлж, нийслэл хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу баруун тийш өргөжин тэлэх, дагуул хот, шинэ суурьшлын бүс байгуулах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд

бодитой хувь нэмэр оруулж байна.

Усны Компакт хөтөлбөр нь манай улсын усны салбарт тулгамдаж байсан асуудлуудыг цогцоор нь харж, дэд бүтцийн үйлдвэр байгууламж барихаас гадна салбарын тогтолцоо, менежментийг шинэ шатанд гаргах шинэчлэлийг хослуулан хэрэгжүүлж чадсанаараа онцлог юм.

Миний бие Усны компакт хөтөлбөрийн хүрээнд бүтээн байгуулсан хоёр үйлдвэрийн бүтээн байгуулалтаас эхлээд, үйл ажиллагааг эхлүүлэх хүртэлх хугацаанд төр, засгийн төлөөлөл, бүтээн байгуулагчидтай хамт байсандаа баяртай байна.

Манай улсын нийслэл Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл эрчимтэй өссөөр байна. Энэхүү хурдацтай өсөлтийг даах ус, эрчим хүч, зам тээврийн суурь дэд бүтцийн асуудлыг урьдчилан харж, урт хугацаанд төлөвлөн шийдвэр гаргах нь Төрийн эрхэм үүрэг билээ.

Урт хугацаанд бодит үр өгөөжөө өгөх, улс орныхоо ирээдүйн хөгжлийг баталгаажуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх томоохон хөтөлбөрийг Монгол, Америк хоёр улс хамтран амжилттай хэрэгжүүлсэнд баяртай байна.

Энэхүү нөр их бүтээн байгуулалтыг товлосон хугацаандаа багтаан бодит болгон хэрэгжүүлж чадсан төслийн удирдагчид, Монголын болон олон улсын инженер техникийн ажилтнууд, нийт бүтээн байгуулагчид, АНУ-ын Засгийн газар, АНУ-ын Элчин сайдын яам, Мянганы сорилтын корпорац, Америкийн ард түмэнд Монголын ард түмний нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Чандмань эрдэнэ болсон усны дусал бүрийг хайрлан хамгаалж, зөв зохистой хэрэглэх нь эрхэм Таны эх дэлхий, ирээдүй хойчдоо оруулах үнэтэй хувь нэмэр билээ.

Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай. ■



УЛААНБААТАР ХОТ **УСНЫ ТУСГААР** **ТОГТНОЛОО** БАТАЛГААЖУУЛАВ

Нийслэл хотын оршихуйн үндэс болсон гол мөрнөө бид сүүлийн жилүүдэд “мартсаар” ирсэн

Улаанбаатараа хайрлая гэвэл усаа хайрла

Улаанбаатар хотод асуудал мундахгүй. Метрополис хот учраас асуудал аяндаа урган гарах нь аргагүй юм. Гэхдээ Улаанбаатарын олон бэрхшээл дунд автозамын түгжрэл, хог хаягдлын сул менежмент, ногоон бүсийн хангалтгүй хүртээмж, замбараагүй хот төлөвлөлт, агаарын бохирдол зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалсан нь дийлэнх. Эдгээр асуудал, бэрхшээлийг бид ухаалаг менежмент, зөв зохистой төлөвлөлт, сэтгэлгээний өөрчлөлт, хөрөнгө санхүүгээр шийдэх бүрэн боломжтой. Харин ийн шийдэх боломжгүй эрсдэл, бэрхшээл нь байгалийн хүчин зүйлээс эхлэлтэй билээ. Улаанбаатар хотын хувьд тэдгээр асуудлын нэг, цагийн тохируулгатай чимээгүй “тэсрэх бөмбөг” нь ус хангамж байсан юм.

Дэлхийн ихэнх соёл иргэншил, томоохон суурин газар, хотууд хэзээд гол, нуур зэрэг усан хангамжаа түшиглэн бий болж байсныг түүх нотлон харуулдаг. Улаанбаатар хот ч Хатан Туул голоо хаяалан бууриа засаж байсан билээ. Гэвч байгаль эхээс заяасан энэхүү “бэлэг”, нийслэл хотын оршихуйн үндэс болсон гол мөрнөө бид сүүлийн жилүүдэд үргэлж “мартсаар”, үл хайхарсаар ирсэн. Үүний жишээ нь өдгөө ширгэн устаж үгүй болохдоо тулаад буй Сэлбэ, Дунд гол, Ногоон нуурууд юм. Үнэндээ бид Хатан Туул голоо ч үргэлж байх мэт санаж, ямархуу нөхцөлд ороод байгааг нь анзаарахгүй явснаа Туулын хурдны зам төслийн дуулиан дэгдэх үед л гэнэт ойлгосон гэхэд хилсдэхгүй. Гэтэл Улаанбаатар хотын ус хангамж үндсэндээ Туул голын сав газрын газрын доорх уснаас ▶

Усны Компактын санхүүжилтээр “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжсэн төслүүд

- Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл
- Хаягдал ус дахин боловсруулах төсөл
- Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл

► бүрддэг бөгөөд нийслэлийн хүн амын 95 гаруй хувийг хангадаг стратегийн эх үүсвэр юм. Сүүлийн үеийн судалгаагаар энэ систем эмзэг, дарамтад орсон гэж үнэлэгдэж байна. Туул голын сав газарт байрлах гүний усны ордуудын ашиглалт жил ирэх тусам нэмэгдэж, хүн амын өсөлт, барилгажилт, үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр 2030 он гэхэд усны эрэлт нийлүүлэлтээс давж болзошгүй гэсэн тооцоо хүртэл гарч байв. Түүнчлэн Туул голын урсац сүүлийн 20–30 жилд мэдэгдэхүйц буурч, хуурай, гандуу жилүүдэд хот орчмын хэсгээр усны түвшин эрс багасан, зарим салаа, татам хэсгүүд тасалдах нь нэмэгджээ. Үүн дээр Туул гол их хэмжээний бохирдолд өртөх болсныг нэмбэл улаанбаатарчуудын усны асуудал дунд болон урт хугацаандаа томоохон сорилт болох нь тодорхой байлаа.

Америкийн ард түмэнд талархахын учир

Монгол Улсын төр, нийгэм, эдийн засаг, хүн амын төв болсон Улаанбаатар хотын ус хангамжийн нөөц, суурь дэд бүтэц ийм асуудалтай байгааг олж харж, Усны компактыг хэрэгжүүлсэн нь улаанбаатарчуудын хувьд азын тэнгэр ивээсэн хэрэг байлаа гэхэд хилсдэхгүй.

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-ын хооронд байгуулсан Мянганы сорилтын анхны Компакт гэрээ 2008-2013 онд хэрэгжиж дууссаны дараа хоёр дахь компакт гэрээг хэрэгжүүлэх улс төрийн шийдвэр гарч, хоёр тал бэлтгэл ажилдаа оржээ. Мэдээж тухайн үед усны салбарт төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө байгаагүй. Хоёр дахь Компакт гэрээг боловсруулж, хэлэлцээ хийх үүрэг бүхий Үндэсний ажлын алба 2015 оны тавдугаар сард байгуулагдсан бөгөөд эхний ээлжинд МСК-ын мэргэжилтнүүдтэй хамтран “Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч хүчин зүйлсийн судалгаа”-г гүйцэтгэжээ.

“МСК-ын МСС Model нь хөрөнгө оруулалтын бүх шийдвэрийг тоо баримт, дүн шинжилгээ, судалгаанд тулгуурлаж хийдгээрээ онцлог.

Ийм учраас Монгол Улсын хөгжлийг ямар асуудлууд боомилж байгаа талаарх судалгааг Монгол, Америкийн талууд хамтран гүйцэтгэсэн байдаг. Уг судалгааны үр дүнд суурилан улам бүр нарийвчлан судалсаар компактын санхүүжилтээр Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх, болзошгүй хомсдолоос сэргийлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэе гэж шийдсэн” хэмээн Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл өгүүлжээ.

Монгол Улсын Засгийн газар болон МСК ийнхүү АНУ-ын татвар төлөгчдийн 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжих Мянганы сорилтын II Компакт гэрээ буюу Усны Компактад 2018 оны долоодугаар сарын 27-нд гарын үсэг зурсан бол УИХ тус гэрээг 2019 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр соёрхон баталлаа.

АНУ-ын Мянганы сорилтын корпорац бол шударга, ардчилсан засаглал, эдийн засгийн эрх чөлөөг дэмжиж, хүн амдаа хөрөнгө оруулалт хийх хүсэл сонирхол бүхий хөгжиж буй орнуудтай хамтран ажилладаг гадаад тусламжийн агентлаг юм. Өөрөөр хэлбэл, АНУ-ын иргэдийн татварын мөнгө ийнхүү алс холын Монгол Улсын нийслэлийг 2050 он хүртэл усны хангамждаа санаа зовохгүй тайван амьдрах боломжийг бүрдүүлж өгчээ. Түүнчлэн төслийн багийнхны хэлснээр “мянган бэрхшээл”-ийг туулсан боловч хөтөлбөрт багтсан гурван төслийг төлөвлөсөн хугацаа, баталсан төсөвт багтаан үндэсний болон гадаадын аж ахуйн нэгжүүд, мэргэжилтнүүдийн хамтаар амжилттай бүтээн байгуулж, хүлээлгэн өгснийг онцлох ёстой.

Ташрамд дурдахад, Мянганы сорилтын корпорац тун цөөн улсад хоёр хөтөлбөр хэрэгжүүлсэн. Монгол Улсад гурав дахь компактыг хэрэгжүүлэх тохиолдолд нүүрснээс эрчим хүч гаргах, газрын ховор элемент, боловсрол, соёлын чиглэлээр хамтран ажиллах саналыг манай улс тавьжээ. Хэрэв дараагийн хөтөлбөрийг хэрэгжүүлвэл тус корпорацын гурван хөтөлбөрийг хүлээж авсан анхны улс нь Монгол болно. ■

Гурван төслийг төлөвлөсөн хугацаа, батлагдсан төсөвт багтаан амжилттай хэрэгжүүлэв

Хөрөнгө оруулалт

461.7

сая ам.доллар

АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж:

350

сая ам.доллар

Монгол Улсын Засгийн газар:

111.7

сая ам.доллар

Ричард Буанган

АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд



Хоёр улсын хамтдаа хийж бүтээсэн бүхнээр бид бахархаж байна

Өнгөрсөн таван жилийн хугацаанд Мянганы сорилтын корпорацын Усны компакт бол хоёр орны нөхөрлөлийн хамгийн тод харагдахуйц илэрхийлэл байсаар ирлээ. Хурдацтай өсөн нэмэгдэж байгаа хэдий ч хамгийн чухал нөөцийн нэг болох усны асуудалтай тулгарч буй хотын ирээдүйг баталгаажуулахад АНУ болон Монгол Улс энэхүү компактаар дамжуулан амжилттай хамтран ажиллалаа. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр нь Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын бат бөх харилцаа, хамтын ажиллагааг илэрхийлээд зогсохгүй Монголын ард түмэн олон үеэрээ ашиглах үйлдвэртэй болсон. Өөрөөр хэлбэл, иргэдийг ариун цэврийн шаардлага хангасан цэвэр усаар найдвартай хангах боломж ийнхүү бүрдэж байна.

Энэ бүтээн байгуулалт нь зүгээр нэг барилга байгууламж биш. Хоёр улсын Засгийн газар болон хоёр орны татвар төлөгчдийн дэмжлэг, хамтын хүчин чармайлтын үр дүнд бий болсон үнэт бүтээл юм. Мөн Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр ашиглалтад орсноор Мянганы сорилтын корпорацын II Компакт гэрээний хэрэгжилт амжилттай дуусаж байна. Тиймээс энэхүү үйлдвэрийг Монгол Улс, тэр дундаа Улаанбаатар хотын захиргаанд хариуцуулан хүлээлгэн өгч байгаа бөгөөд цаашид олон үе дамжин өвлөгдөн үлдэх үнэ цэнтэй бүтээн байгуулалт болно гэдэгт итгэлтэй байна.

Бидний хамтдаа хийж гүйцэтгэсэн зүйл зөвхөн дэд бүтэц гэдэг утгаараа биш, харин юуг илэрхийлж байгаа нь чухал юм.

Америкийн туршлага Монголчуудын шаргуу хөдөлмөр Бидний хамтын алсын хараа Монголын ирээдүйд итгэх бидний итгэл Бас манай хоёр орны харилцан итгэлцэл Энэ бүхнийг нэг дор авчирлаа. Усны аюулгүй байдал бол Улаанбаатарын ирээдүйн үндэс суурь

юм. Эдийн засгийн өсөлт, нийгмийн эрүүл мэнд, хөрөнгө оруулалт, амьдрах чадварыг дэмжинэ. Мөн ирээдүй хойч үеийнхэнд бүтээх, шинийг сэдэх, цэцэглэн хөгжихөд нь илүү их баталгаа, тогтвортой байдлыг бий болгоно. Гэхдээ магадгүй хамгийн чухал нь ил тод түншлэл, хамтын амлалтаар юунд хүрэх боломжтойг энэ компакт харуулж байна. Энэ долоодугаар сард тохиох АНУ-ын тусгаар тогтнолын 250 жилийн ойн босгон дээр хүчирхэг ардчилал урт хугацаанд оршин тогтнохын үндэс суурь бол сайн засаглал, хариуцлага, иргэний оролцоо, мөн улс орныхоо эдийн засгийн өсөлтийг түүчээлж чадах хүчирхэг хувийн хэвшил юм гэдгийг бидэнд сануулж байна.

Монголд ажиллах хугацаандаа би МСК-ын Усны компактын оролцогч талууд болох төр засгийн албаныхан, инженер-техникийн мэргэжилтнүүд, операторууд болон Монголын Мянганы сорилтын сангийн гайхалтай багийнхны мэргэжлийн өндөр ур чадвар, авьяас, үнэнч зүтгэлийг өөрийн нүдээр харлаа. Энэхүү компактаар хийгдсэн ажил зөвхөн мэргэжлийн шилдэг ур чадвар төдийгүй, тэвчээр, алсын харааг бас харуулж байна.

АНУ Монгол Улсыг ардчиллын чухал түнш, үнэ цэнэтэй гуравдагч хөрш гэж тууштай ханддаг. Манай хоёр улсын хамтдаа хийж бүтээсэн бүхнээр бид бахархаж, ирээдүйгээ ч өөдрөгөөр харж байна.

Энэхүү компактын амжилт нь ил тод байдал, хариуцлага, хамтын зорилгод тулгуурласан хөрөнгө оруулалт бол ард иргэд, салбар бүрт урт хугацааны ашиг тусыг авчирч чадна гэсэн чухал мессежийг өгнө гэж би итгэж байна. Монголчууд “Нөхрийн хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ” гэж ярьдаг. Ард иргэдийнхээ амьжиргаа, амьдралын чанарыг сайжруулахад Монгол Улс амжилт гаргаж буйг харах нь АНУ-ын хувьд ч амжилт мөн билээ. ■

Дэн Пэтри

АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч



Эдийн засгийн өсөлтийн түншүүд болох шинэ үе шат руу орж байна

Монгол Улс эдийн засгаа хувийн хэвшилд түшиглэн төрөлжүүлж буй энэ үед найдвартай дэд бүтэц, тэр дундаа усны тогтвортой хангамж маш чухал байна. Усны Компакт хөтөлбөрийн үр дүнд урт хугацааны ус хангамжийг баталгаажуулснаар үйлдвэрлэлийн шинэ салбарууд хөгжих, эдийн засгийн өсөлтийг хязгаарлагч эрсдэлийг бууруулах боломж бүрдэж байна. Мөн энэ нь Улаанбаатар хотын өрсөлдөх чадвар, цаашдын хөгжлийг дэмжих бодит баталгаа болж байгаа юм. Компакт хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр бид хөгжлийн хамтын ажиллагааг бодит үр дүнд хүргэж, бүтээн байгуулалтаас ашиглалтын шатанд шилжиж байна. Түүнчлэн хамтран бүтээн байгуулагчаас эдийн засгийн өсөлтийн түншүүд болох шинэ үе шат руу хамтдаа орж байна гэж харж байна. АНУ-ын Засгийн газрын нэрийн өмнөөс та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Энэхүү Компакт хөтөлбөр нь манай хоёр улсын хамтын түншлэл, эдийн засгийн боломж, өсөлтийн төлөөх нийтлэг зорилгын бат бөх бэлгэ тэмдэг болон үлдэнэ гэдэгт итгэлтэй байна.

Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын иргэдээр зогсохгүй бизнес болон үйлдвэрлэлийн салбарт томоохон өөрчлөлт авчирлаа. Шинээр гаргасан усны худаг, дэвшилтэт ус гүн цэвэршүүлэх технологи болон системийн шинэчлэл нь хурдацтай өсөн тэлж буй нийслэл хотыг цэвэр, найдвартай усаар хангаж, 460,000 өрхийн аж амьдралд шууд нөлөө үзүүлэх юм. Түүнчлэн усны нөөцийн удирдлагыг ирээдүйд тогтвортой хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай удирдлага болон зохицуулалтын томоохон шинэчлэлүүдийг төслийн хүрээнд нэвтрүүлээ. Ингэснээр Улаанбаатар хот нь цаашдаа тогтвортой өсөн тэлэх, хөрөнгө оруулалт татах, дараа үеийн иргэддээ эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх боломжтой болж байна.

Корпорацийн зүгээс ил тод байдал, бодит баримт нотолгоонд суурилсан шийдвэр, үр дүнг нэн тэргүүнд тавьдаг бөгөөд компакт хөтөлбөр дууссаны дараа ч үр өгөөж нь үргэлжилж байхад анхаарал хандуулж

төлөвлөдөг. Хамгийн чухал нь компакт хөтөлбөр жинхэнэ түншлэлийг бий болгож чаддагт оршино.

Нийт 462 сая ам.долларын хөрөнгө оруулалтын 112 сая ам.долларыг Монгол Улс санхүүжүүлсэн нь Мянганы сорилтын корпорацийн түүхэнд түнш орны оруулсан хамгийн өндөр хувьтай хөрөнгө оруулалтад тооцогдож байна. Энэ нь Монгол Улс төслийн амжилтад багагүй хувь нэмэр оруулсныг илтгэнэ.

Хэрэгжилтийн онцлог талуудаас дурдвал Мянганы сорилтын корпорац нь гүйцэтгэгч болон зөвлөхүүддээ төлбөрийг шууд олгодог бөгөөд хөрөнгийн захиран зарцуулалт өндөр түвшний хяналт, шалгуурт нийцэж байгаа эсэхийг олон шатны системээр баталгаажуулдаг. Хяналтын бусад механизмд Санхүүгийн агент, Худалдан авах ажиллагааны агентууд багтдаг бөгөөд тус агентууд нь Мянганы сорилтын корпорацийн журам мөрдөгдөж байгаа эсэхийг хянадаг. Мянганы сорилтын корпорацийн Компакт хөтөлбөр нь улс орнуудын бие даасан байдлыг бэхжүүлэх зорилготой. Тиймээс одоо хамгийн гол нь хүрсэн үр дүнг урт хугацаанд тогтвортой хадгалах явдал юм. Монгол Улсын техникийн болон институцийн тогтолцоо, хууль эрх зүй, бодлого зохицуулалтыг бэхжүүлж өгсөн нь эдгээр системийг цаашид бие даан удирдах боломжийг бүрдүүлж өгч байна.

Мөн бүхий л томоохон хөрөнгө оруулалтад бие даасан үнэлгээ хийгддэг. Үүгээр хөтөлбөр зорилтот бүлэгтээ хүрсэн эсэх, орлого нэмэгдсэн эсэх, хөрөнгө оруулалт үр ашигтай байсан эсэх, цаашдын хөтөлбөрүүдэд ямар сургамж өгөх вэ гэдгийг үнэлж дүгнэдэг юм. Мянганы сорилтын корпорац нь өгөгдөл, үр дүн, үнэлгээгээ олон нийтэд ил тод нээлттэй болгодоггоороо бас онцлог. Тэгэхээр бидний түншүүд ямар ажил үр дүнгээ өгсөн, харин ямар ажил бүтээгүйг шууд харж болно. Хэдийгээр энэхүү компактаар Мянганы сорилтын корпорацийн албан ёсны оролцоо өндөрлөж байгаа хэдий ч Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улсын өргөн хүрээний түншлэл цаашид ч олон салбарт үргэлжлэх болно. ■



Х.Нямбаатар

Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын Захирагч

НИЙСЛЭЛИЙН УСНЫ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ **2030 ОН ХҮРТЭЛ ҮРГЭЛЖИЛНЭ**

Нийслэлд
80 гаруй
үйлдвэр,
аж ахуйн
нэгжид ус
цэвэршүүлэх
байгууламж
нэн
шаардлагатай
байна

АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацын буцалтгүй тусламжаар улаанбаатарчууд усан хангамждаа ойрын хэдэн жилдээ санаа зовохооргүй болж чадлаа. Усны компакт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн, ач холбогдлын хувьд мега төсөл гэж хэлж болохоор гурван төслийн эдийн засгийн үр ашгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Монгол Улсын усны салбар, тэр дундаа Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээ, АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй томоохон төслүүдийн талаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатартай ярилцлаа. Энэхүү ярилцлагыг 2026 оны дөрөвдүгээр сард хийсэн болно.

Усны компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн гурван төсөл нь Монгол Улсын усны салбарт стратегийн ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалт боллоо. Зөвхөн эдийн засгийн өгөөжөөр хэмжихээс илүүтэй иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, хотын цаашдын хөгжлийн суурийг бэхжүүлж буй нь хамгийн чухал. Нэгдүгээрт, ▶

► Усны компакт гэрээний хүрээнд усны шинэ эх үүсвэрийг бий болгож, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг урт хугацаанд тогтвортой хангах боломж бүрдэж байна. Ингэснээр зөвхөн усны хэрэгцээг хангаад зогсохгүй хотын бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн суурийг бүрэлдүүлж байгаа хэрэг.

Хоёрдугаарт, дэвшилтэт ус цэвэршүүлэх үйлдвэр төслийн хүрээнд улсын хэмжээнд орчин үеийн өндөр түвшний ус цэвэршүүлэх технологийг Монголд нэвтрүүлсэн. Ингэснээр манай улсын усны чанар, аюулгүй байдал, найдвартай ажиллагаа шинэ шатанд гарч байна. Өөрөөр хэлбэл, бид зөвхөн усны нөөцөө нэмээд зогсохгүй тэр нөөцийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах боломжтой боллоо.

Гуравдугаарт, бохир усыг нэг удаа хэрэглээд хаяхгүйгээр бохир ус дахин боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна. Энэ бол бохир усыг дахин боловсруулах тогтолцооны эхлэл болох юм. Үр дүнд нь цэвэр усаа хэмнэнэ. Усны нөөцийг хамгаална. Тогтвортой хөгжлийг дэмжинэ зэргээр ач холбогдлыг нь харвал өргөн цар хүрээтэй.

Дээрх гурван төсөл бол Монголын усны салбарт шинэ эх үүсвэр, шинэ технологи, шинэ тогтолцоог авчирч, усны салбарын тогтвортой хөгжлийг бий болгож байна.

Усны компакт хөтөлбөр дууссаны дараа эдгээр байгууламжийн үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээр тогтвортой санхүүжүүлэхээр тооцоолж байгаа вэ?

Мэдээж усны үйлчилгээний үнэ тариф нь бодит өртөг, зардлаа нөхөх хэмжээнд хүрэхгүй бол ийм том дэд бүтцийг урт хугацаанд тогтвортой ажиллуулахад хүндрэл үүснэ. Өөрөөр хэлбэл, үйлчилгээний байгууллага өртөг, зардлаа нөхөж чадахгүй бол цаашдын тогтвортой байдал эрсдэлд орно гэсэн үг.

Өнөөдрийн байдлаар манай улсад нэг литр усны үйлчилгээний дундаж өртөг 2.65 төгрөг байгаа бол тариф нь дунджаар 1.18 төгрөг байна. Тиймээс үйлчилгээнийхээ тогтвортой ажиллагааг хангахын тулд усны тарифыг дунджаар гурван төгрөгт хүргэх шаардлага бий.

Нийслэлийн усны хэрэглээ сүүлийн 10 жилд хэрхэн өссөн бэ, энэ өсөлт цаашид хэрхэн өөрчлөгдөх төлөвтэй байна вэ? Гүний усанд тулгуурласан өнөөгийн систем, хангамж урт хугацаандаа тогтвортой байж чадах уу?

Улаанбаатар хотын хүн амын өсөлттэй зэрэгцэн усны хэрэглээ сүүлийн 10 жилийн хугацаанд хурдтай өсөж байна. Цаашид ч өснө. Арван жилийн өмнө Улаанбаатар хот батлагдсан гүний усны нөөцийнхөө 58 хувьтай тэнцэх хэмжээний усыг ашиглаж байсан. Харин 2025 оны байдлаар 70 хувьтай тэнцэх хэмжээний усыг өдөрт хэрэглэж байна. 12 хувийн өсөлттэй гэсэн үг. Усны хэрэглээ хурдтай өсөж байгаа учраас гүний усанд тулгуурласан өнөөгийн системээр урт хугацаандаа хэрэглээг хангана гэдэг сайн шийдэл биш.

Усны компакт төслийн үр дүнд гүний усны хэрэглээг тогтвортой барьж, усны хэрэглээг нөхнө. Төслүүд бүрэн хэрэгжиж дуусаад, 2030 он гэхэд Улаанбаатар хотын иргэдийн усны хангамж, хэрэглээнд хэд хэдэн бодит өөрчлөлт гарна гэж харж байна.

Нэгдүгээрт, усны хүртээмж нэмэгдэнэ. Шинэ дэд бүтцүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломж бүрдэж, иргэдийн амьдралын чанарт шууд эерэг нөлөө үзүүлнэ. **Хоёрдугаарт**, бохир ус дахин боловсруулж, дулааны цахилгаан станц зэрэг томоохон хэрэглэгчид гүний ус хэрэглэхээ багасгаж, хэмнэсэн усыг иргэд, аж ахуйн нэгж хэрэглэнэ.

Гуравдугаарт, дэвшилтэт ус цэвэршүүлэх технологи нэвтрүүлснээр олон улсын стандартад нийцсэн чанартай усыг шинэ эх үүсвэрээс хэрэглэгчдэд түгээх боломж бүрдэж байна.

Дөрөвдүгээрт, ус хэрэглэх соёл, хандлага өөрчлөгдөнө. Усны нөөц хязгаарлагдмал гэдгийг ойлгож, хэмнэлттэй, ухаалаг хэрэглээнд шилжих суурь болно. Дүгнэж хэлбэл, 2030 он гэхэд Улаанбаатар хот тогтвортой, найдвартай ус хангамжтай, үр ашигтай хэрэглээтэй хот болох суурийг өнөөдрөөс тавьж байна.

Хэрэв АНУ-ын ард түмний буцалтгүй тусламж гэж хэлж болохоор энэхүү хөрөнгө оруулалт хийгдээгүй байсан бол нийслэлийн усны хэрэглээ ямар хязгаарт хүрэх байсан бэ?

Усны компакт гэрээний төслүүд хэрэгжээгүй байсан бол Улаанбаатар хотын усны салбарын тулгамдсан асуудлууд илүү хурцдах эрсдэл учирна. Юун түрүүнд, усны нөөцийн хомсдол бодит хязгаартаа ойртох байлаа. Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэржилт, хотжилт тасралтгүй өсөж байгаа энэ үед шинэ эх үүсвэргүйгээр зөвхөн одоогийн газрын доорх усны нөөцөд түшиглэх нь усны эх үүсвэрийн ачааллыг нэмэгдүүлж, урт хугацаандаа усны тогтвортой

Дээрх гурван төсөл бол Монголын усны салбарт шинэ эх үүсвэр, шинэ технологи, шинэ тогтолцоог авчирч, усны салбарын тогтвортой хөгжлийг бий болгож байна

Нэг литр усны үйлчилгээний дундаж өртөг 2.65 төгрөг байгаа бол тариф нь дунджаар 1.18 төгрөг

▶ хангамжид ноцтой эрсдэл үүсгэх байсан. Мөн эдийн засаг, хот байгуулалтын хөгжил усны нөөцийн боломжоор хязгаарлагдах байлаа. Шинэ орон сууцны хороолол, үйлдвэрлэлийн бүс, дэд бүтцийн өргөтгөлүүд усны хүртээмжгүйгээс шалтгаалан удаашрах, эсвэл хязгаарлагдах нөхцөл үүсэх байсан. Түүнчлэн бохир усыг дахин ашиглаж чадалгүй өндөр чанарын цэвэр усыг үйлдвэрлэлийн зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах байлаа. Энэ нь ундны усны нөөцөд нэмэлт дарамт болж, усны үр ашиггүй хэрэглээг улам даамжруулах эрсдэлтэй.

Товчхондоо, эдгээр төсөл хэрэгжээгүй бол усны хомсдол, хүртээмжийн асуудал, нөөцийн дарамт, хөгжлийн хязгаарлалт зэрэг асуудлууд илүү ноцтой түвшинд хүрч, Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийн нэг том саад болох байсан.

Иргэдийн хувьд дахин боловсруулсан “саарал ус” гэдэг ойлголтод итгэх итгэл сул байдаг. Энэ тал дээр ямар стандарт, баталгаажуулалт, хяналтын механизм ажиллаж байгаа вэ?

“Саарал ус” гэдэг ойлголтоо эхлээд тайлбарлая. “Саарал ус” гэдэг нь зөвхөн ахуйн хэрэглээнээс гарч байгаа буюу шүршүүр, гар угаагуур, угаалгын машинаас гарч байгаа бага бохирдолтой усыг хэлдэг. Үүнд, ариун цэврийн өрөөний суултуур, гал тогооны угаагуурын бохир ус хамаарахгүй. Өнөөдөр Улаанбаатар хотод орон сууцны хотхон, хорооллуудад “саарал ус”-ыг цэвэршүүлэн дахин ашиглаж байгаа туршлага бараг байхгүй. Мөн нийслэлд 80 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгжид ус цэвэршүүлэх байгууламж нэн шаардлагатай байна.

Харин Мянганы сорилтын корпорацын II компакт гэрээний хүрээнд баригдсан үйлдвэр бол “Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр” юм. Тус үйлдвэр саарал ус биш хаягдал усыг дахин боловсруулна. Бүр тодорхой хэлбэл, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдэж, байгальд нийлүүлэх хаягдал усыг дахин боловсруулж үйлдвэрийн хэрэгцээнд дахин ашиглах зориулалтаар баригдсан үйлдвэр юм. Тэгэхээр барилга доторх ахуйн ▶



► “саарал ус”-ыг дахин ашиглах систем болон төв цэвэрлэх байгууламжаас байгальд нийлүүлж буй хаягдал усыг дахин боловсруулж ашиглах систем нь технологи, цар хүрээ, хяналтын хувьд өөр.

2025 онд “Дахин ашиглах цэвэрлэсэн ус MNS 6734:2025” стандарт батлагдсанаар дахин боловсруулсан усыг дулааны цахилгаан станц, бетон үйлдвэрлэл, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэр болон зам талбайн тоос дарах зэрэг техникийн зориулалтаар ашиглах эрх зүйн орчин бүрдсэн.

Мөн дахин боловсруулсан усны чанарт лабораторийн шинжилгээг өдөр тутамд хийдэг болсон. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс гарч буй цэвэрлэсэн ус нь MNS 6734:2025 стандартын шаардлагыг бүрэн хангаж байгаа нь томоохон дэвшил юм.

Гэр хорооллын ус түгээх худгуудыг автоматжуулах ажил хэр үр дүнтэй байна вэ. Энэ нь үйлчилгээний чанараас гадна хэрэглээний хяналтад ямар өөрчлөлт, дэвшил авчирсан бэ?

АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацын буцалтгүй тусламжаар гар ажиллагаатай ус түгээх 182 байрыг бүрэн автоматжуулсан. Ус түгээх автомат худгууд нь иргэдийн өдөр тутмын амьдралыг хялбарчилж, усны зардлыг хэмнэж байна. Одоогийн байдлаар нийт 306 автоматжуулсан, ухаалаг ус түгээх байруудаар гэр хорооллын хэрэглэгчдийг унд, ахуйн цэвэр усаар хоногийн 24 цаг тасралтгүй хангаж буй. Ухаалаг ус түгээх байруудын үйл ажиллагааг Хяналт удирдлагын төвөөс SKM (smart koick managment) системээр веб программ ашиглан хянадаг.

Нийслэл хотын бас нэг тулгамдсан асуудал нь Төв цэвэрлэх байгууламж болоод байгаа. Тус байгууламжийн өнөөгийн бодит байдал болон шинэ төв цэвэрлэх байгууламж барих төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Улаанбаатар хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, туршилт, тохируулгын ажил 2025 оны долоодугаар сард эхэлсэн. Нийт 18 сарын хугацаанд туршилт, горим тохируулга үргэлжилнэ. Өнөөдрийн байдлаар хоногт 100-110 мянган шоо метр бохир ус хүлээн авч цэвэрлэж байна. 2026 оны тавдугаар сараас усны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж, долоодугаар сараас бүрэн хүчин чадлаар ажиллаж эхлэх бөгөөд хуучин байгууламжийн үйл ажиллагааг зогсооно.

УС ТҮГЭЭХ АВТОМАТ ХУДГУУД:

- 24/7 үйлчилгээ үзүүлж байна.
- Төлбөр тооцооны олон сонголт/hipay, socialpay, Qpay/
- Гар утасны Ussuvagsmartkoick аппликэйшн
- Хэрэглээг тогтмол хянах боломжтой



АНУ-ын ард иргэдийн сайн санааны буцалтгүй тусламжид улаанбаатарчууд маань талархах ёстой байх гэж бодож байна. Та энэ талаар юу хэлэх вэ?

Улаанбаатар хот олон талт, тэгш, хүртээмжтэй гадаад харилцааны бодлого баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацын буцалтгүй тусламжийн төслүүд Монгол Улс төдийгүй Улаанбаатар хотын усны салбарт чухал дэмжлэг болж байгаа юм.

Төслүүдэд хамтран ажилласан баг, хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж, цаашдын хамтын ажиллагаагаа илүү шинэ шатанд гаргаж, илүү ахиц дэвшилд хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын ундны усан хангамжийн асуудлыг шийдэхэд зориулж, их хэмжээний буцалтгүй санхүүжилт олгосон Америкийн ард түмэн, татвар төлөгчдөд маш их баярлаж байгаагаа илэрхийлье. Мөн 100 гаруй сая ам.доллар гаргасан Монголынхоо ард түмэн, татвар төлөгчдөдөө ч баярлалаа гэж хэлье.

Энэхүү мега төслийн тухай Mongolian Econo-ту сэтгүүлийн тусгай дугаараар дамжуулан юуг бүтээж, ямар үр дүнд хүрэх гэсэн бүтээн байгуулалт болсон талаар монголчууд, тэр дундаа улаанбаатарчууддаа ойлгуулан таниулж мэдүүлэхийг хүслээ. Монголын ирээдүй болсон хүүхэд залууст ч баримт болон үлдэх дугаар болно гэдэгт итгэж байна. ■

Хотын шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулах тохируулгын ажил 2025 оны долоодугаар сард эхэлсэн

ХОТЫГ АВАРСАН ХОЛЫН ХҮМҮҮСТ **БАЯРЛАЛАА**

Улаанбаатарчууд 2050 он хүртэл усгүйдэхийн зовлон үзэхгүй тайван амьдрах бололцоотой боллоо. Хариуцлагатай байж чадвал үеийн үед чандмань эрдэнэдээ тэтгүүлэн амьдарна.



Д.Доржсүрэн

Гидрогеологич, газарзүйн ухааны доктор

Усны компакт хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрүүд хаягдал усаа урьдчилан цэвэрлэнэ. Одоогоор 100 аж ахуйн нэгжээс 28 нь цэвэрлэх байгууламжтай болжээ

Улаанбаатар хот усгүй болох тухай мэдээ үе үеэн эрчийг авдаг байсныг уншигч та мартаагүй байх. 2000-аад оноос эхлэлтэй эл таагүй мэдээ таван жил тутам хангинадаг сэрүүлэг шиг л байсан. Гэхдээ энэ бүх анхааруулга хий хоосон байгаагүй. Туулын сав, гүний усны нөөц, хотжилтын дарамт, гангийн давтамж, хэрэглээний өсөлтөөс урган гарсан бодит тооцоолол байсан.

Харин энэ дугаарт “Mongolian Economy” сэтгүүл илүү гэрэлтэй мэдээг дайж байна. 2030 он гэхэд усны хомстолд орох тод улаан анхааруулгатай амьдарч байсан нийслэлчүүд бид усгүйдэхийн зовлонг тойрч чадлаа. АНУ-ын Мянганы сорилтын корпорацаас хэрэгжүүлсэн Усны компакт хөтөлбөр улаанбаатарчуудад 2050 он хүртэл сэтгэл амар аж төрөх боломжийг олгоод байна. “Хэрэв ус бохирдуулагч аж ахуйн нэгжүүд дор бүрнээ хэрэглэсэн усаа дахин цэвэрлэж, эргүүлэн ашигладаг болчихвол 2100 он хүртэл ч тайван амьдрах боломжтой” хэмээн гидрогеологич, газарзүйн ухааны ▶



Гэрэл зургийг Г.Ган-Өлзий

► доктор Д.Доржсүрэн хэлж байна. Үүгээр барахгүй Улаанбаатар хотын усан хангамж 2016 оны түвшинтэй харьцуулахад 80 хувиар нэмэгдсэн гэсэн таатай мэдээг тэрбээр дуулгав.

Д.Доржсүрэн гуай байгаль орчин, тэр дотроо усны салбарт нэгэн насаа зориулж яваа эрдэмтэн судлаач хүн. Тиймдээ ч усны нөхцөл байдлыг зөвхөн өнөөдрөөр бус, түүхэн цаг үеэр нь харж чаддаг. Улаанбаатар хот 1978 оноос эхэлсэн их гангийн улмаас усны гачигдалд орж, 1980-аад онд зарим хорооллыг цагийн хуваарийн дагуу усаар хангаж байсан түүхтэй. Мөн 1996 оноос эхлэлтэй жил дараалсан ган гачиг Хатан Туулыг туйлдуулж, 2006-2007 онд Туул гол Улаанбаатар хот орчимд 7-10 км тасарч байсан халаглам үе бий. Тэр үед Монгол Улс гадаргын усныхаа 30 гаруй хувийг алдаж, 1500 шахам гол горхи, 3000 орчим булаг шанд ширгэж байжээ. “Түймрийн гал орон даяар авалцаж, үндсэн ажлын хажуугаар түймрийн жижүүрт хонож ажиллахад тэр хоног өдрүүд ажил мэргэжлийн минь үнэ цэнийг зүрхэн тушаа

сийлэх шиг л болсон” хэмээн Д.Доржсүрэн гуай дурсаж байв.

Түүний туурвисан ном бүтээл, салбарын яам, олон улсын байгууллагуудын хүсэлтээр хийсэн судалгаа шинжилгээ, оролцсон ажлууд нь усны нөөц тогтоох, бодлого тодорхойлох, ирээдүйгээ төлөвлөх, гарц шийдэл хайхад чиглэж байсан. Тэр бүү хэл Усны компакт хөтөлбөр хэрэгжих үндэс суурь нь болсон юм.

Судалгаа бол бүхний суурь

Мянганы сорилтын корпорац монголчуудын ус хангамж руу хараагаа чиглүүлэхээс өмнө эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах олон хувилбар судалж үзсэн байна. Эцэст нь ус хамгийн чухал гэдгийг эрдэмтдийн судалгаанаас олж харжээ. Усны нөөц, хангамжийн талаарх судалгааг Д.Доржсүрэн гуай 2014-2015 онд удирдан гүйцэтгэж, гурван боть суурь тайлан гаргасан. Тайланд нийслэлчүүд 2000 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд усны эх үүсвэрийг барилгаар шахан

Туулын хөндийд амьдарч буй хүн бүр усаа хайрлах мөнхийн хариуцлагыг цаг ямагт санаж явах учиртай



▶ бетонжуулж, их хэмжээгээр бохирдуулсныг шүүмжилжээ. Мөн үүнээс шалтгаалан 1982 онд тогтоосон Улаанбаатар хотын усны нөөцийн 30 гаруй хувь нь эргэн сэргэхээргүй болсон талаар сануулсан байна.

Түүний оролцсон дараагийн том судалгаа нь Дэлхийн банкны дэргэдэх “2030 Усны нөөцийн бүлэг”-ийн судалгаа юм. Энэ судалгаанд Улаанбаатар хотын усны нөөцийг эх үүсвэртэй нь тулган тооцоолж, маш “хатуу” дүгнэлт танилцуулсан. Тодруулбал, “2030 он гэхэд Улаанбаатар хот одоо байгаа эх үүсвэрээрээ усны эрэлтээ хангаж чадахгүй, дутагдалд орно” гэсэн дүгнэлт юм. Тиймээс цэвэр усны шинэ эх үүсвэр нэмэхээс гадна техникийн хэрэглээнд ундны ус ашигладаг үрэлгэн байдлыг өөрчлөх шаардлагатайг тус судалгаанд онцолжээ.

Америкийн ард түмний бэлэг

Гидрогеологич, газарзүйн ухааны доктор Д.Доржсүрэн манай сэтгүүлээр дамжуулан Америкийн ард түмэнд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна. Учир нь Америкийн ард түмний 350 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн Усны компакт хөтөлбөр Улаанбаатарын хөгжлийг тэтгэх гурван том бэлэг барьсныг тэрбээр тодотгов.

Эхнийх нь, Шувуун фабрик, Биокомбинатын орчимд алтны ордоос ч үнэ цэнтэй усны ордыг “олборлоход” бэлнээр нь хүлээлгэн өгсөн явдал юм. Баруун эх үүсвэр ашиглалтад орсноор хоногт 140 мянган тонн усыг нийслэлийн унд, ахуйн хэрэглээнд нийлүүлэх нөхцөл бүрдсэн. Харин удаах нь Хатан Туулын алжаалыг тайлах Ус дахин боловсруулах үйлдвэр бол гурав дахь нь усны салбарын засаглал, тариф, хяналт, лаборатори, автоматжуулалтыг дэмжих замаар институцийн хөгжлийг дэмжиж буй нь юм.

Энэ гурван бэлгээс Ус дахин боловсруулах үйлдвэрийн үнэ цэнийг тоогоор тодруулсан нь анхаарал татаж байлаа. Нийслэлчүүд бид хагас дутуу цэвэрлэсэн усаа Туул голдоо цутгаж ирсэн. Төв цэвэрлэх байгууламжаас Туул руу нийлүүлдэг усны хэмжээ хоногийн 130-160 мянган тонн. Жилээр нь тооцвол 50 сая тонн. Энэ бол Туулын бохирдлын гол хүчин зүйл. Харин дахин боловсруулах үйлдвэр байгуулагдсанаар өдөр бүр 50 мянган тонн усыг Туулд цутгахаас урьтаж дахин боловсруулдаг болоод байна. Хамгийн чухал нь дахин боловсруулсан усыг ДЦС-3, ДЦС-4 зэрэг томоохон станцад нийлүүлснээр үнс зайлуулж, систем хөргөхөд дахин боловсруулсан ус

ашигладаг болсон. Станцууд хоногт 30 мянган тонн ус техникийн хэрэгцээнд ашигладаг бөгөөд өмнө нь унданд хэрэглэж болох усаар станцыг “булхуулдаг” байсан нь дэндүү хайран байсан юм.

Станцаар зогсохгүй ус бохирдуулагч аж ахуйн нэгжийн хариуцлага Усны компакт хөтөлбөрийн хүрээнд шинэ шатанд яригдаж эхэлсэн. Улаанбаатар хотод ойролцоогоор 6000 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдгаас 100 орчим нь усны өндөр бохирдол үүсгэдэг томоохон бохирдуулагчид. Тухайлбал, арьс шир боловсруулах, хүнс үйлдвэрлэх явцад усыг маш ихээр бохирдуулдаг. Гэвч хаягдсан усыг урьдчилан цэвэрлэлгүйгээр төвлөрсөн системд нийлүүлдэг нь усны салбарын зовлон болж хувирсан. Харин хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрүүд хаягдал усаа урьдчилан цэвэрлэх зарчим хүчтэй тавигдсанаар бохирдуулагч 100 аж ахуйн нэгжээс 28 нь цэвэрлэх байгууламжаа байгуулаад байна. Үлдсэн нь ойрын жилүүдэд асуудлыг шийдэх амлалт өгчээ.

Гашуун сургамж

Улаанбаатарчуудад Туулын ус хуралдан тогтдог, хурын усыг нөөцлөн тогтоодог 10 хүрэхгүй эх үүсвэр бий. Эдгээрийг аягатай усаар зүйрэлбэл, амсрыг нь үүрд мөнх таглана гэдэг асар том мунхаглал. Ийм мунхаглалын золиос болсон эх үүсвэр бол Үндэсний цэцэрлэгт хүрээлэн орчмын эх үүсвэр. Хотын унд, ахуйн хэрэглээний 40 орчим хувийг дангаар хангадаг энэ эх үүсвэрт 96 гүний худаг байрладаг. Гэтэл байгаль эхийн нөөцлөх савыг нийслэлчүүд бетоноор шахсаар л байна. Бүр худгийг нь хүчээр акталж байгаад барилгажуулсан тохиолдол ч бий. Сэтгүүлч миний бие нийтлэлийнхээ төгсгөлд гидрогеологич Д.Доржсүрэнгийн ярианаас нэгэн агуулгыг нэмэлт хачиргүйгээр дайя.

“Усны эх үүсвэрийн бүсэд барилга байгууламж, шатахуун түгээх станц барьж хөлийн газар болгох нь байгаль эх, хүн төрөлхтний эсрэг хийж буй гэмт хэрэг. Нөгөөтээгүүр, стандарт шаардлага хангасан усыг унд ахуйдаа хэрэглэх нь хүний үндсэн эрх. Гэхдээ энэ эрхийн цаана мөнхийн үүрэг, хариуцлага бий. Үүнийг Туулын хөндийд амьдарч буй хүн бүр цаг ямагт санаж явах учиртай. Ялангуяа бидэнд дэлхийн олон хотод тэр бүр заяагаагүй ариун тансаг ус заяасан. Иймд чандмань эрдэнээ нүдний цөцгий мэт хайрла. Аврагдсан ирээдүйгээ улам бүр нандигна” хэмээн тэрбээр хэлсэн билээ. ■

“Усны эх үүсвэрийн бүсэд барилга байгууламж, шатахуун түгээх станц барьж хөлийн газар болгох нь байгаль эх, хүн төрөлхтний эсрэг хийж буй гэмт хэрэг

УСНЫ КОМПАКТ
УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТ УС ХАНГАМЖИЙГ
**НЭМЭГДҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР**



ГҮН ЦЭВЭРШҮҮЛЭХ ҮЙЛДВЭР

ШИНЭ ГҮНИЙ ХУДАГ: **30**


Жилд **50 сая** тонн ус гүн цэвэршүүлнэ




18 мянган тонн ундны ус хадгалах, газар доорх усан сан байгуулав

Шувуун фабрик орчим-**16**

Биокомбинат орчим-**14**



Хүний үсний ширхгээс **700 мянга дахин** нарийн зайгаар ус шүүх технологи



Гүний худгийн насос нь секундэд **72-74 литр** ус сорох хүчин чадалтай

600 мм диаметртэй гүний худгийн цооног-Монголын хамгийн том цооног


ҮЙЛДВЭРИЙН ОРЧИМД:

УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Үйлдвэрийн орчимд **600 гаруй мод** тарив



Шувуун фабрикийн эх үүсвэрийн талбайд **10,000 мод** тарьсан



180 орчим инженер, техникийн ажилтныг сургалтад хамруулав

180 худгийн автоматжуулж, 24 цагийн ажиллагаатай болгов

ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Төв цэвэрлэх байгууламжийн **50 мянган** тонн хаягдал усыг цэвэршүүлнэ



Жилд **14-18 сая** шоо метр орчим гүний цэнгэг усыг хэмнэнэ



Жилд **дөрвөн Буйр нууртай** тэнцэх хэмжээний гүний цэвэр ус хэмнэнэ



Газар доогуур **12 км ус** дамжуулах шугам хоолой барив



Ц.Мөнх-Оргил

УИХ-ын болон Засгийн газрын гишүүн асан, өдгөө Монгол Улсаас Франц улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд



УСНЫ КОМПАКТ БОЛ ХЭД ХЭДЭН ЗАСГИЙН ГАЗРЫН ХИЙСЭН АЖИЛ, ОЛСОН АМЖИЛТ

Усны компакт гэрээ хэрхэн зурагдаж, энэ том хөтөлбөр хэрхэн эхэлж, ямар зам туулсан талаар тус санаачилгыг Монголд хэрэгжих эхлэлийг тавилцсан анхдагчдын нэг Ц.Мөнх-Оргилтой ярилцлаа.

Бид бүгд тал талаасаа хүчин зүтгэсний ачаар хийж, дуусгаж чадсан

Мянганы сорилтын корпорацын (МСК) Усны компакт гэрээг хэлэлцэх, байгуулах шатанд чухал оролцоотой байсан хүмүүсийн нэг нь та. Тэгэхээр та компакт гэрээтэй анх хэрхэн холбогдсон бэ. Тэр үеийн нөхцөл байдлыг эргэн санавал?

2016 оны долоодугаар сард Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын Засгийн газарт Гадаад хэргийн сайдаар томилогдож, Мянганы сорилтын корпорацын хоёр дахь компакт гэрээг боловсруулах, хэлэлцээ хийх ажлыг удирдан чиглүүлэх Үндэсний хорооны даргаар ажиллаж эхэлсэн. Тэр үеэс л холбогдсон доо. Түүх сануулахад, АНУ 31 оронтой анхдагч компакт байгуулаад, тэд дундаасаа 14 оронтой л хоёр дахь компакт байгуулсан юм. 2015-2018 онуудад хоёр дахь компакт гэрээний хэмжээ, агуулга, зорилгын талаар хоёр тал харилцан ярилцаж, судалж бэлдсэн. Энэ ажилд л миний бие 2016-2017 онд Гадаад хэргийн сайдаар оролцсон.

Гэрээнд 2018 оны долоодугаар сард Д.Цогтбаатар сайд Вашингтон хотноо гарын үсэг зурсан. Эндээс харахад, энэ бол Монгол Улсын хэд хэдэн Засгийн газрын хийсэн ажил, олсон амжилт байгаа юм. Эхний компакт сайн хэрэгжээгүй бол хоёр дахь нь хэрэгжихгүй л байсан. Үе үеийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар, ГХЯ, Вашингтон дахь ЭСЯ, элчин сайд, анхны компактыг амжилттай хэрэгжүүлэхэд хүчин зүтгэсэн бүх байгууллага, хувь хүмүүс гээд маш олон хүн, байгууллагын хүчин зүтгэлийн үр дүн л дээ. ▶

► Ялангуяа хоёр дахь компакт гэрээ байгуулах орнуудын жагсаалтад багтах ажлыг 2013-2014 онд хийж чадсан нь маш ач холбогдолтой байсныг дурдах хэрэгтэй. Үүнд, тухайн үед Вашингтонд Элчин сайдаар ажиллаж байсан Б.Алтангэрэл чухал үүрэг гүйцэтгэсэн. Ингээд 2014 оны арванхоёрдугаар сард хоёр дахь компакт гэрээ байгуулж болох орны жагсаалтад багтаад, 2015 оны тавдугаар сард гэрээн дээр ажиллах Үндэсний хороог байгуулаад, бэлтгэл ажил эхэлсэн. Ийм байдалтай л 2016 оны УИХ-ын сонгуулийн дараа миний бие энэ төсөлтэй золгосон доо.

АНУ-ын талтай хэлэлцээ хийх үед ямар сорилтууд тулгарч байв?

Айхтар их сорилт ч юу байх вэ дээ. Авлигын индекс, засаглал, ардчиллын үзүүлэлтүүд хангагдаж байгаа, анхны компакт гэрээ амжилттай хэрэгжиж үр дүнгээ өгснийг нотлох ажлыг өмнөх Засгийн газрын үед хийсэн учраас бидний хувьд энэ үзүүлэлтүүдийг бууруулахгүй хадгалах, дараагийн компакт гэрээг түргэн тохирох ажил чухал байсан.

Миний гол ажил бол алдсан цаг хугацааг нөхөх, төслийг бүх шатанд ойлгуулах, холбогдох шийдвэрүүдийг түргэн шуурхай гаргах байсан. Хоёрдахь компакт байгуулах орны тоонд орсноос хойш жил хагас өнгөрч, тэр хооронд сонгууль гээд ажил цалгардчихсан, олон асуудал хуримтлагдчихсан, нөгөө тал маань тэвчээр алдсан байдалтай байсан. Хоёрдахь компакт гэрээ байгуулах бусад орон бараг бүгд төслөө тохирчихсон, “ойрын үед шийдвэрээ гаргахгүй бол танайд хуваарилсан мөнгийг өөр улс руу шилжүүлэх гээд байна, хурдлаарай” гэж байнга анхааруулна.

Шийдэх ёстой эхний асуудал нь ямар салбарыг сонгох, хөрөнгийг юунд зарцуулах вэ гэдэг асуудал байсан. Олон санал, төсөл байсан ч усны хангамж дээр төвлөрөх гэдэг санал зонхилсон. Яагаад усны хангамжийн асуудал гарч ирсэн гэдэг нь их сонин. Анх манайхан хөдөө аж ахуй, зам, банкны салбар гээд олон санал тавьж байсан юм билээ. АНУ-ын Засгийн газар энэ төслийг Монголын хувийн секторыг хөгжүүлэхэд зориулах санал гаргасныг нь манай Засгийн газар зөвшөөрсөн. Харин чухамхүү юунд төвлөрөх, Америкийн ард түмний буцалтгүй тусламжийн 300-400 сая ам.долларыг яаж аль болох үр дүнтэй, олон хүнд хүртээмжтэй, хувийн бизнесийн хөгжилд урт хугацаандаа ашигтай зарцуулах вэ гэдэг асуудал тулгарсан.

Ингээд АНУ-ын Засгийн газар “Монголын хувийн

секторын хөгжлийг боомилж байгаа хүчин зүйлс” гэсэн судалгааг өөрсдөө хийгээд, хот хөдөөгийн олон зуун бизнес эрхлэгчидтэй уулзаад манай улсын хувийн секторын хөгжлийг боомилж байгаа хүчин зүйлсийн талаар тун сонирхолтой дүгнэлт хийсэн. Гурван хүчин зүйлийг онцолсон: нэгдүгээрт, хууль тогтоомж, дүрэм журам, татвар хураамжийн тогтворгүй, ойлгомжгүй, олон янзаар тайлбарлагддаг байдал; хоёрдугаарт, санхүүжилт үнэтэй буюу зээлийн хүү өндөр байгаа; гуравдугаарт, усны үнэ бөгөөд хангамжийн асуудал. Энэ гурван асуудал хувийн секторын хөгжлийг боомилж байгаа гол хүчин зүйлс гэж тодорхойлсон. Эхний хоёр асуудлыг бол та бүхэн өөрсдөө л шийдэх юм байна, бидний оролцох боломжгүй асуудлууд байна гэсэн. Харин усны хангамж, нэн ялангуяа Улаанбаатар хотын усны хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлж болно гэж үзсэн. Яг л голыг нь олсон, одоо ч гэсэн ач холбогдлоо алдаагүй дүгнэлтүүд. Зав гарвал та бүхэн уншаад үзээрэй. Усны хангамж бизнесүүдийн хувьд том асуудал болчихсон байгааг бид мэдээгүй л байсан. Өнөө ч сайн ойлгохгүй л байх шиг.

Усны үнэ хямд, өртгөөсөө хамаагүй доогуур учраас хүмүүс ер нь ач холбогдол өгдөггүй, үрэлгэн зарцуулдаг, ялангуяа орон сууцны хорооллынхон. Харин гэр хороололд, эсрэгээрээ, ус харьцангуй үнэтэй. Аж ахуй эрхлэгч нарын хувьд, ялангуяа ус их хэрэглэдэг салбарынхны хувьд усны үнэ маш өндөр, хүртээмж муутай болохоор бизнесээ хөгжүүлэхэд нь саад тотгор болдог. Энэ байдал өнөөдөр өөрчлөгдсөн зүйлгүй шүү дээ.

Америкчуудын хийсэн энэ судалгаанд, яаралтай зохион байгуулалтаа өөрчилж, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, хууль тогтоомж, хүмүүсийн хандлагаа өөрчлөхгүй бол Улаанбаатар хот ойрын 20 жилийн дотор усны огцом дутагдалд орох аюул байгааг үндэслэлтэй, тооцоо, судалгаатай харуулсан. Би энэ судалгааг уншаад тэр дор нь хувийг нь УИХ-ын гишүүд, сайд дарга нарт хүргүүлж байснаа санаж байна.

Ингээд хоёрдахь компакт гэрээний үндсэн зорилгыг тохиролцож, холбогдох шийдвэрүүд гарсны дараа гэрээний хүрээнд юу хийх, ямар төслүүд хэрэгжүүлэх вэ гэдгийг тохирох нь чухал болсон. Энэ бол нарийн тооцоо, судалгаа шаардсан, гадаад дотоодын мэргэжлийн хүмүүс, байгууллага оролцсон, бүтэн нэг жил хагасын хугацаанд хийгдсэн ажил. Үндэсний хорооны даргын хувьд би ажлыг ерөнхийд нь чиглүүлэх, яам, газруудыг шахах, уялдуулах л ажлыг хийнэ шүү дээ. Гол ажлыг Э.Содонтогосоор ахлуулсан

Америкийн ард түмний буцалтгүй тусламжийн 300-400 сая ам.долларыг яаж аль болох үр дүнтэй, олон хүнд хүртээмжтэй, хувийн бизнесийн хөгжилд урт хугацаандаа ашигтай зарцуулах вэ гэдэг асуудал тулгарсан

► ажлын алба нугалсан. Э.Содонтогос дарга, тэдний аппарат хичээл зүтгэлтэй, мэргэжлийн өндөр түвшинд ажилласан, богино хугацаанд компакт гэрээг бүрдүүлэх гурван том төслийг тохирох, тооцоо судалгааг дуусгах, баримт бичиг бүрдүүлэх гээд асар их ажлыг амжуулсан.

Үүний хажуугаар Америкийн талд манай нөхцөл байдлыг тайлбарлах, Монголын талд Америкийн талын тавьж байгаа шаардлагыг ойлгуулах гэж зуучилна, хоёр талд хоёуланд нь зэмлүүлнэ. “Яасан их дэмий юм нэхдэг юм бэ” гээд л манайхан сүйд болно, “яагаад хариу өгөхгүй таг чиг болчихдог юм бэ” гээд л америкчууд нь бухимдана. Ийм яриа өдөр болгон болно, гомдол тасрахгүй. Гэхдээ л бид бүгд тал талаасаа хүчин зүтгэсний ачаар хийж, дуусгаж чадсан.

Гэрээ батлагдсаны дараа Э.Содонтогос Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирлаар томилогдсон. Нэг онцлох зүйл бол, энэ төсөл дээр АНУ-ын болон Монгол усны шилдэг мэргэжилтнүүд гар нийлж ажилласан. Тийм ч учраас төслүүд амжилттай хэрэгжсэн. АНУ-ын талаас, жишээ нь, Мянганы сорилтын сангийн ахлах захирал, усны салбар хариуцсан гол эксперт Кумар Ранганатан манай төсөл дээр ажилласан. Йордан, Зүүн Тимор, Сьерра-Леоны усны төслүүдийг хэрэгжүүлсэн энэ хүнээр төслөө техникийн талаас нь удирдуулах гэж бид АНУ-ын туслах Төрийн нарийн бичгийн дарга (Ази хариуцсан) Сюзан Торнтоны дэмжлэгийг авч байлаа. Мянганы сорилтын корпорацийн орлогч захирал Жонатан Брукс мөн Монголд их элэгтэй, олон асуудал дээр тусалж байсныг заавал дурдах хэрэгтэй.

Манай талаас М.Мягмар, Н.Буянхишиг доктор гээд Монголын усны гол мэргэжилтнүүд оролцсон. Энэ төсөлд чухал үүрэг гүйцэтгэсэн

Америк, Монгол олон хүн байгаа, би бүгдийг нь энд яаж нэрлэж чадах билээ. Бүгдэд нь талархаж явдаг гэж энэ ташрамд хэлье.

Компакт гэрээнээс танд, Монгол Улсад сургамж болсон зүйл гэвэл?

Бид “Ус чандмань эрдэнэ” гэж лоозогнодог болохоос биш энэ чухал асуудалд хангалттай анхаарал хандуулдаггүй, мэргэжилтнүүдийнхээ үгийг тоодоггүй хүмүүс юм билээ. Хаа байсан Америкаас хүн ирээд, “нийслэл хот чинь тун удахгүй усгүй болох нь байна шүү, бид буцалтгүй тусламж өгье, асуудлаа зах зухаас нь ч гэсэн шийдээч” гэхээр нь л хөдөлсөн. Гэхдээ бас бүтэн гүйцэд хөдлөөгүй л байна. Бид усны менежмент, удирдлагын тогтолцоогоо шинэчлэх, усны тарифаа өөрчлөх, усанд гамтай орчин үеийн технологи нэвтрүүлэх, татвар, санхүүгийн хөшүүрэг бий болгох, хүн ардын дунд соён гэгээрүүлэх ажлаа эрчимжүүлэх хэрэгтэй.

АНУ-ын буцалтгүй тусламжийн 350 сая ам.доллар, Монголын талын 112 сая ам. доллар гээд нийт 462 сая ам.долларын энэ төслөөр бид Биокомбинат, Шувуун фабрик орчим гүний худгууд гаргаж, шинэ эх үүсвэртэй, шинээр гаргаж авсан усаа гүн цэвэрлэх үйлдвэртэй, хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэртэй боллоо.

Гэхдээ энэ бол асуудлыг хэсэг хугацаанд л шийдэж байгааг мартаж болохгүй. Цаг уурын өөрчлөлт, хуурайшилт, Улаанбаатар хотын хүн амын өсөлт, бизнесийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг бодохоор бид шинэ эх үүсвэр бүрдүүлэх, усаа гамтай хэрэглэж сурах, хүмүүсийн дадал зуршлыг өөрчлөх, шинэ технологи нэвтрүүлэх гэх мэт олон ажлыг зэрэг хийж байж л улаанбаатарчуудыг найдвартай усаар хангах юм. Энэ л гол сургамж. ■

Бид “Ус чандмань эрдэнэ” гэж лоозогнодог болохоос биш энэ чухал асуудалд хангалттай анхаарал хандуулдаггүй, мэргэжилтнүүдийнхээ үгийг тоодоггүй хүмүүс

АНУ 31 оронтой анхдагч компакт байгуулаад, тэд дундаасаа 14 оронтой л хоёр дахь компакт байгуулсан.

Компакт гэрээ байгуулах орнуудын жагсаалтад багтах ажлыг 2013-2014 онд хийж чадсан нь маш ач холбогдолтой.

Б.ЖавхланУИХ-ын гишүүн, Сангийн
сайд асан**Засгийн газар санхүүжилтийн 25 хувийг
цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн**

Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд байгуулагдсан Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсон нь Монгол Улсын усны нөөцийг хамгаалах стратегийн ач холбогдол бүхий томоохон МЕГА төсөл болсон. Энэхүү төсөл нь Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы Сорилтын корпорацын II Компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн бөгөөд бүтээн байгуулалтын үе шат нь цар тахлын хүнд үетэй давхацсан хэдий ч анх батлагдсан хугацаа, төсөвтөө багтан амжилттай хэрэгжиж дууссан нь онцлог юм. Тус компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн уг төслийн үр дүнд Улаанбаатар хотын усан хангамж жилд 50 сая шоо метрээр нэмэгдэх боломж бүрдэж, нийслэлийн цаашдын өргөжин тэлэлт, тогтвортой хөгжлийн чухал суурийг бүрдүүлсэн бүтээн байгуулалт болж чадлаа. Монголчууд “ус бол чандмань эрдэнэ” хэмээн эрхэмлэдэг. Энэ төслийг товч тодорхойлбол “бидний ус – бидний ирээдүй” хэмээн дүгнэж болох юм. Сүүлийн жилүүдэд нийслэлчүүдийн ундны усны хэрэглээ эмзэг, эрсдэлтэй түвшинд хүрч байсан. Хэрэв энэхүү хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн төсөл

хэрэгжээгүй бол өнөөдөр Улаанбаатар хотын өмнө тулгамдах хамгийн том сорилт нь ундны усны хомсдол болох байлаа. Тодруулбал, хоёр том дулааны цахилгаан станц жилд ойролцоогоор 14-18 сая шоо метр усыг технологийн хэрэгцээндээ газрын гүний цэвэр уснаас авч ашигладаг байсан. Харин энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор уг хэмжээний усыг дахин боловсруулж, саарал усыг технологийн зориулалтаар орлуулах боломж бүрдсэнээр ундны усны нөөцөд үзүүлэх дарамт бодитоор буурлаа. Төслийн нийт санхүүжилт 461.7 сая ам.доллар бөгөөд үүнээс 350 сая ам.доллар нь АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж юм. Монгол Улсын Засгийн газар өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд нийт санхүүжилтийн 25 хувийг цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, санхүүжилтийн тасалдал үүсгэлгүйгээр төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Энэхүү бүтээн байгуулалт нь Улаанбаатар хотын усны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлсэн, стратегийн өндөр ач холбогдолтой томоохон төсөл болж чадлаа. ■

Ц.Цогтбаатар

УИХ-ын гишүүн

**Хөгжлийн гацаа болохуйц эрсдэлээс
урьдчилан сэргийлж чадлаа**

Мянганы Сорилтын корпорацын компакт гэрээг Монголд хэрэгжүүлэх санаачилгыг анх гардан эхлүүлж явсан багийн нэг гишүүний хувьд тэр үеийн зүтгэл маань өнөөдөр бодит бүтээн байгуулалт болж байгааг хараад баяртай байдаг. Яриа хэлэлцээ чамгүй хугацаанд үргэлжилсний дүнд хоёр дахь гэрээний эрх зүйн суурь гэрээ (үүнийг албажуулан эцэслэх тунхагт Ерөнхий сайд гарын үсэг зурсан)-г зурах боломжийг бүрдүүлж ажилласнаа эргэн дурсахад яахын аргагүй сайхан. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор аж ахуйн нэгжүүд дахин боловсруулсан ус ашиглах боломж бүрдэж, гүний цэвэр усны

нөөцийг хамгаалах боломж бүрдлээ. Энэ бол Монгол Улсыг ус цэвэршүүлэх технологийн шинэ эринд алхуулж буй стратегийн бүтээн байгуулалт юм. Ер нь Мянганы сорилтын корпорацын суурь зорилго нь амжилттай яваа улс үндэстнийг үгээр биш, үйл хэргээр дэмжиж, олонд хүрсэн бүтээн байгуулалтыг босгох юм. Монгол Улсын эдийн засгийн ихэнх хувь нь Улаанбаатарт төвлөрсөн. Усны хомсдолд орвол энэ бүгд шууд гацаанд орно. Тиймээс усны асуудлыг шийдвэрлэхгүйгээр Улаанбаатар хотын цаашдын хөгжил, хөрөнгө оруулалтын өсөлтийн тухай ярих боломжгүй байсан ▶

▶ гэж болно. Хөгжлийн гацаа болохуйц энэ эрсдэлийг бид бодитой болохоос нь өмнө урьдчилан сэргийлж, Мянганы сорилтын корпорацитай хамтран шийдлээ гэсэн үг. Цаашдаа хамгийн чухал нь энэ төслийг авч явах мэргэжлийн боловсон хүчнээ тогтвортой ажиллуулах шаардлагатай байгаа. Энэ төслийн бас нэг том ололт бол технологийн мэдлэг, ур чадвар, ноу-хау Монгол талдаа шилжсэн. Үүнийг бэхжүүлж

хадгалж, цааш хөгжүүлэх нь мэдээж нэн чухал.

Мөн усны салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход онцгой анхаарах хэрэгтэй. Технологи, дэд бүтэц нь бэлэн болсон ч институцийн чадавх, хүний нөөц, бодлогын тогтвортой байдал дагаж бэхжихгүй бол энэ хөрөнгө оруулалтын бодит үр өгөөж бүрэн гарахгүй. Ус бол зөвхөн байгаль орчны асуудал биш. ■

Б.Хулан

Сангийн дэд сайд,
Монголын Мянганы
сорилтын сангийн
Удирдах зөвлөлийн
дарга



Мега төслийг амжилттай хэрэгжүүлсэн туршлага сайн жишиг тогтоож чадлаа

Байгалийн баялгийг бид голцуу уул уурхайн нөөцөөр төсөөлдөг. Гэвч үнэндээ хамгийн чухал нөөц бол ус юм. Усгүй амьдрал, усгүй эдийн засаг, усгүй үйлдвэрлэл үйлчилгээ гэж нэгээхэн ч үгүй. Тийм ч учраас ус хангамж бол хүн төрөлхтний амьдралын чанар, нийгэм, эдийн засаг, тогтвортой хөгжлийн эх булаг билээ. Үүгээр зогсохгүй улс үндэстний оршин тогтнохуй, аюулгүй байдлын баталгаа нь ус юм.

Нийслэл Улаанбаатар хотын усны нөөц 2020-оод оны дундаас хомсгож эхлэх талаар салбарын эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагууд сануулж байсан. Харин 2021-2026 онд хэрэгжсэн Усны компакт хөтөлбөрийн хүрээнд бидний өмнө тулгамдаад байсан усны асуудал бүрэн шийдэгдлээ. Энэ утгаараа компакт хөтөлбөр нь усны салбарт сүүлийн 30 жилд хийгдээгүй хамгийн том хөтөлбөр, цаашлаад Монгол Улсын хэмжээнд хэрэгжсэн хамгийн чухал ач холбогдолтой төсөл, хөтөлбөрийн нэг болоод байна.

Миний хувьд 2025 оны арванхоёрдугаар сард Сангийн дэд сайдаар томилогдсон даруйдаа Монголын мянганы сорилтын сангийн Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж эхэлсэн. Энэ цагаас хойш төслийн хэрэгжилттэй холбоотой цаг үеийн тулгамдсан асуудал, шийдэл хүлээж байсан хэд хэдэн бэрхшээлийг цаг алдалгүй шийдвэрлэж ажилласан маань нэр төрийн хэрэг юм. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд Монгол

Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац тус тусын үүргээ бүрэн биелүүлж, өндөр түвшинд харилцан ойлголцож, хамтран ажилласны үр дүнд төлөвлөсөн ажлууд хугацаандаа, батлагдсан төсөвтөө багтаж амжилттай хэрэгжиж дууслаа. Мөн хөтөлбөрийг 2022 оны есдүгээр сард Сангийн яаманд шилжүүлж, Удирдах зөвлөлийг Сангийн яам ахлах болсон нь яамд, төрийн байгууллагын уялдаа холбоо, зохион байгуулалтыг саадгүй хэрэгжүүлэхэд оновчтой шийдэл болсныг энд онцлох нь зүйтэй.

Энэхүү цогц хөтөлбөрийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газар бүх түвшинд онцгой анхаарч, хүлээсэн үүргээ чандлан биелүүлсэн нь төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжихэд чухал хөшүүрэг болсон. Томоохон бүтээн байгуулалтуудаас гадна усны салбарын бодлого, санхүүгийн орчныг боловсронгуй болгож, институц, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, урт хугацааны тогтвортой байдлыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд Компакт хөтөлбөр ихээхэн дэмжлэг үзүүлээ. Усны компактын үр дүнд Монгол Улс болон АНУ-ын стратегийн түншлэл эдийн засгийн бодит агуулгаар баяжиж, шинэ түвшинд гарсан гэж үзэж байна. Хамгийн чухал нь дэд бүтцийн мега төслийг амжилттай хэрэгжүүлсэн энэхүү туршлага цаашид хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд сайн жишиг тогтоож, үндэстний мэргэжилтнүүдийн чадавх, чадамжийг бэхжүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой байлаа. ■

З.Батбаяр

Усны газрын дарга



Ус хангамжийн хүчин чадал 50-60 хувиар нэмэгдэнэ


Монгол орны нийт усны нөөцийн ердөө хоёр хувийг газрын доорх ус эзэлдэг. Бид нөөцөө зохистой ашиглахын тулд зохицуулалт хийхээс өөр аргагүй. Өөрөөр хэлбэл, тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт хийж усны барилга байгууламж барих шаардлагатай байсан. Усны компакт гэрээний хүрээнд Улаанбаатар хотод гурван том төсөл хэрэгжиж байна. Эдгээр төсөл усны нөөцийн ашиглалтыг сайжруулах, дахин хэрэглээг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байгаа нь салбарын мэргэжилтний хувьд талархалтай зүйл мөн. Улаанбаатарын ус хангамжийн гол эх үүсвэр болох төвийн эх үүсвэр жилд 34 сая метр куб ус нийлүүлдэг. Ус хангамжийн баруун эх үүсвэр ашиглалтад орсноор нийслэлийн ус хангамжийн хүчин чадал мэдэгдэхүйц буюу 50-60 хувиар нэмэгдэнэ. Энэ нь өсөн нэмэгдэж буй хүн ам, хотжилтын нөлөөг даах ус хангамжийн чадавхыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

Улаанбаатар хотын иргэд өдөр тутамдаа 100 хувь гүний цэвэр ус хэрэглэдэг. Түүнчлэн дулааны цахилгаан станцууд жилд нийслэлийн нийт усны хэрэглээний 23.8 хувийг газрын доорх усны эх үүсвэрээс авч ашигладаг. Үүний 18.0 сая метр кубыг хөргөлт, угаалга цэвэрлэгээ, үнс зайлуулахад ашигладаг. Усны компакт гэрээний хаягдал ус дахин боловсруулах төсөл хэрэгжсэнээр 21 сая орчим метр куб усыг дахин ашиглах боломж бүрдэнэ. Ингэснээр гүний усны нөөцөд ирэх ачааллыг бууруулах үлэмж ач холбогдолтой юм.

Мөн эдгээр төслийн үр дүнд Улаанбаатар хотын усан хангамжийн тогтвортой байдал дунд хугацаанд сайжирч, цэвэр усны хүртээмжийг хангах боломж нэмэгдэнэ. Төслүүдийг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлж чадвал нийслэл хотыг 2035 он хүртэл цэвэр усны хангамжийн хүндрэлгүй байлгах боломж бүрдэнэ. ■

Э.Энхгэрэл

Монголын Мянганы сорилтын сангийн гүйцэтгэх захирал



Хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дараагийн дэд бүтцүүд байгуулах боломж нээгдлээ

Цэвэр баталгаатай усаар хангагдах нь хүний суурь эрх. Монгол Улсын хөгжлийг чөдөрлөх асар том эрсдэлийг бид амдан шийдэж чадлаа. Аливаа асуудлын шийдэл мэргэжлийн боловсон хүчин, санхүү хоёр дээр хүрээд зогсох нь элбэг. Компактын санхүүжилтээр байгуулсан дэд бүтцийн үйл ажиллагааг хариуцах хүний нөөцөө бид өнгөрсөн гурван жилийн хугацаанд бэлдсэн.

Иймд цаашид бодлого төлөвлөлт, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дараа дараагийн дэд бүтцүүд байгуулах боломж нээгдэж байна. Ус хангамжийн асуудлыг шийдэхийн тулд төрөөс анхаарч, Компактын хүрээнд түүхэн гэж хэлж болох томоохон хөрөнгө оруулалт

хийж дэд бүтцийг ашиглалтад орууллаа. Мянганы сорилтын сангийн хамт олон хүсэл зорилго нэгтэй байж төслөө бүрэн хэрэгжүүлж, буцалтгүй тусламжийн санхүүжилтийг эх орондоо хэрэгтэй зүйлд заавал шингээж үлдэх юм шүү гэж ажилласан.

Компакт хэрэгжсэнээр бий болсон бас нэг давуу тал нь салбарын хэмжээнд тулгамдаад байсан олон асуудлыг олон нийтийн, тэр дундаа шийдвэр гаргагчдын анхааралд оруулсан явдал. Гэрээнд туссан хаягдал усны стандартыг хангуулах төлөвлөгөө хэрэгжсэнээр зөвхөн байгууламжийн ажиллагаа биш Туул голын бохирдлын асуудлыг шууд бусаар хөндөж байгаа. ■

Д.Мэндсайхан

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн захирал



18 сая орчим метр.куб усыг дахин ашиглах боломж бүрдэнэ

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал 18 сая шоо метр. Үүнийхээ 12 саяыг станцуудад нийлүүлнэ. Үлдсэнийг нь өөр газруудад шилжүүлэн ашиглах боломжтой. Үйлдвэрийг барихдаа ирээдүйд өргөжин тэлэх боломжийг маш сайн төлөвлөсөн. Цаашид үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Үйл ажиллагаандаа

гүний цэвэр ус ашиглаж байгаа ААН-үүд усны дөрвөн төрлийн төлбөр төлдөг байсан бол манай усыг хэрэглэснээр хоёр төлбөрөөс нь чөлөөлөгдөнө. Үйлдвэрээ тогтвортой, үр ашигтай авч явахын тулд дахин боловсруулсан ус ашиглах соёлыг төлөвшүүлэх нь чухал. Бас дахин ашиглах цэвэрлэсэн усыг хуульд албан ёсоор томьёолж, үнэ тарифыг батлах хэрэгтэй. ■

Б.Батсүх

Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн захирал



Гүн цэвэршүүлэх үйлдвэр цаашид баригдах үйлдвэрүүдийн загвар болно

Улаанбаатар хотод ашиглаж буй долоон эх үүсвэрээс авч байгаа гүний усаа бид ямар нэгэн цэвэршүүлэлт хийхгүй хлоржуулж, халдваргүйжүүлээд шууд хэрэглэж байгаа. Харин төслийн хүрээнд шинээр бий болсон эх үүсвэр бол газрын гүнээс авсан усаа өндөр технологийн дагуу цэвэршүүлж хэрэглээнд нэвтрүүлнэ. Улаанбаатар хотын усны хэрэглээ жилд 100 сая шоо метрт хүрсэн тохиолдолд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр 100 хувь хүчин

чадлаараа ажиллаж эхэлнэ. Одоогоор үйлдвэр цэвэршүүлсэн усаа нийлүүлэх ганцхан шугамд холбогдоод байгаа. Үүнээс өмнө үйлдвэрээс ус авах шугам хоолойн дэд бүтцийг бий болгох хэрэгтэй. Мөн энэхүү гүн цэвэршүүлэх үйлдвэр маань цаашид Монгол Улсад баригдах ус цэвэршүүлэх үйлдвэрүүдийн загвар болно. Иймд өндөр технологийн үйлдвэрт ажиллах мэргэжилтнүүдийг бодлогоор бэлтгэх нь чухал. ■

Л.Өнөржаргал

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал



Усны үйлчилгээний салбар зардлаа нөхөх төлөвлөгөөг боловсрууллаа

Усны компактын хүрээнд ашиглалтад орж буй үйлдвэрүүдийг цаашид авч явах УСУГ-ын хүний нөөцийн чадавхыг сайжруулах нь манай төслийн нэг зорилго. Энэ хүрээнд Нидерланд улсын мэргэжилтнүүдтэй гурван жилийн хугацаанд түншлэлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн. Ингэснээр давхардсан тоогоор УСУГ-ын 180 гаруй инженер техникийн ажилтныг хөрөнгийн удирдлагын сургалтад хамруулсан байна. Бас нэгэн чухал ажил бол усны

үйлчилгээний салбар зардлаа нөхөх тогтвортой байдлын төлөвлөгөөг боловсруулсан явдал. Ус хангамжийн үйлчилгээ өртөг зардал ихтэй. Гэхдээ үнэ тарифыг үргэлж бодит өртгөөс доогуур тогтоож ирсэн. Үүнийг өөрчлөх асуудлыг бид сууриас нь эхэлж бодит судалгаанд суурилан хийж эхлүүлээ. Нийслэлийн иргэдийн 60-80 хувь нь усны үнэ хямд байгааг зөвшөөрч, үйлчилгээ сайжирсан тохиолдолд өндөр үнэ төлөх боломжтой гэж хариулсан. ■

М.Ням-Очир

НААБЗГ-ын даргын
албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч



Улаанбаатар хот хүрээгээ тэлж хөгжих үндсэн суурь нөхцөл бүрдэнэ

Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд шинээр ашиглалтад орж байгаа баруун эх үүсвэр нь Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд жилд 50 сая шоо метр ус нийлүүлэх хүчин чадалтай. Ингэснээр Улаанбаатар хотын өнөөдрийн усны хэрэглээний 80 орчим хувьтай тэнцэх хэмжээний усыг төвлөрсөн ус хангамжийн сүлжээнд нийлүүлэх боломж бүрдэнэ гэж ойлгож болно.

Үр дүнд нь хотын хэрэглэгчид стандартын шаардлага хангасан усаар найдвартай хангагдах байдал нэмэгдэж, цаашид үйлдвэрлэл, үйлчилгээний болон орон сууцны барилга байгууламж барих, хот хүрээгээ тэлж хөгжих үндсэн суурь нөхцөл бүрдэх болно.

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлуулахаар УИХ-д өргөн барьсан. Тус төлөвлөгөө батлагдсаны

үндсэн дээр Улаанбаатар хотыг цаашид хөгжүүлэх бүсчлэл, суурьшлын бүс, дагуул хотуудын төлөвлөлт тодорхой болж, тус төлөвлөлтийн дагуу тэдгээрт шаардлагатай үе шаттайгаар дулаан, цахилгаан, ус хангамж, ариутгах татуургын сүлжээний төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлууд хийхээр төлөвлөж байна.

Улаанбаатар хотын орон нутгийн өмчит байгууллагуудын ашиглалт үйлчилгээг нь хариуцдаг 850 орчим км урт ус хангамжийн шугам бий. Дөчөөс дээш жилийн насжилттай 350 орчим км шугам байна.

Цаашид ус хангамжийн сүлжээг нэмж өргөтгөх, хэрэглэгчдийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, хяналт, удирдлагын системийг бүрэн цахимжуулах, автоматжуулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. ■

Б.Цэрэннадмид

Нийслэлийн Хот
байгуулалт, хотын
стандартын газрын
ахлах мэргэжилтэн



Ус зөвхөн хэрэглэдэг нөөц биш стратегийн чухал баялаг болно

“Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт Улаанбаатар хотын усан хангамжийн өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг зөвхөн гүний усаар хангах бус, 50 хувийг гүний уснаас, 25 хувийг гадаргын уснаас, үлдсэн 25 хувийг дахин боловсруулсан усаар хангах стратеги дэвшүүлсэн. Энэ нь усны эх үүсвэрийг нэмэгдүүлэхээс гадна ус ашиглалтын хандлагыг бүхэлд нь өөрчлөх, усны нөөцийг хамгаалах цогц менежментийн шинэ үе шатны эхлэл болсон. Мянганы сорилтын сангийн Компакт гэрээгээр хийгдсэн харилцан уялдаа бүхий олон ажлууд энэхүү бодлогыг бодит ажил болгох эхлэлийг тавилаа.

Шинээр ашиглалтад орж байгаа Баруун эх үүсвэрийн цэвэршүүлэх үйлдвэр, шугам сүлжээ, хэрэглэгчийн ачаалал, хэрэглээний тооцоог Улаанбаатар хот баруун тийшээ тэлж байгаа шинэ суурьшлын бүсүүдэд хэрэглэхээр төлөвлөсөн. Цэвэршүүлэх үйлдвэрээс төвийн цэвэр усны сүлжээнд холбох ф700мм-ийн шугамын дунд баруун чиглэлийн бүсүүдийг хангахаар холболтын 3-5 худаг хийгдсэн. Эмээлтийн үйлдвэр, технологийн парк хүртэл

500 мм-ийн голчтой дамжуулах шугам, усан сан барих ажлын зураг төсөл хийгдэж байна. Одоо байгаа гүний усны нөөцийг шинээр нэмэгдүүлснээр Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан орон сууц, аж ахуйн нэгжүүдийн хүлээгдэж буй ус хангамжийн хэрэглээг хангах боломж бүрдсэн.

Дахин цэвэршүүлсэн усыг станцуудын хэрэгцээнд ашиглах шийдэлд хүрсэн нь төслийн чухал үр дүн юм. Ингэснээр нийслэлд шинээр баригдахаар төлөвлөсөн дулааны тархмал эх үүсвэрүүдийн технологийн усны хэрэгцээг хангах төдийгүй үйлдвэрүүд, зам талбайн цэвэрлэгээ, авто угаалга зэрэг технологийн хэрэглээнд ашиглах тусдаа системийг хөгжүүлэхээр төлөвлөсөн. Усны компакт гэрээ нь зөвхөн ус хангамжийн нэг төсөл биш харин усны нөөцийг хамгаалах, дахин ашиглах, байгальд ээлтэй байдлаар хөгжих урт хугацааны бодлогын бодит хэрэгжилт юм. Ирээдүйд ус зөвхөн хэрэглэгддэг нөөц биш, харин дахин ашиглагдаж, үнэ цэнэ нь улам нэмэгдэх стратегийн чухал баялаг байх болно. ■

**Ц.Төрхүү**

Ус сувгийн удирдах газар (УСУГ)-ын дарга

КОМПАКТ ГЭРЭЭ УСНЫ САЛБАРТ МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭ АРГА БАРИЛ, СТАНДАРТ АВЧИРЛАА

Чадвартай хүний нөөц бүрдүүлэх нь салбарын амжилтын гол хүчин зүйл

Усны компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн гурван төсөл усны салбарт ямар дэвшил авчирч байна вэ?

Монгол Улсын усны салбарт стратегийн ач холбогдолтой дараах томоохон дэвшлүүдийг авчирч байна.

Нэгдүгээрт, шинэ усны эх үүсвэрийг бий болгосноор Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг урт хугацаанд тогтвортой хангах боломж бүрдэнэ. Энэ нь зөвхөн өнөөдрийн хэрэгцээг хангах бус, цаашдын хот байгуулалт, үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндсэн суурь болж байгаа юм.

Хоёрдугаарт, дэвшилтэт ус цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулснаар манай улсад орчин үеийн өндөр түвшний ус цэвэршүүлэх

технологи нэвтэрч, усны чанар, аюулгүй байдал, найдвартай ажиллагаа шинэ шатанд гарч байна. Өөрөөр хэлбэл, бид зөвхөн усны нөөцөө нэмээд зогсохгүй, тэр нөөцийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах боломжтой болсон.

Гуравдугаарт, бохир усыг дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор усыг нэг удаа хэрэглээд хаядаг биш, дахин ашигладаг тогтолцоонд шилжих эхлэл тавигдлаа. Энэ нь цэвэр усны хэрэглээг хэмнэх, усны нөөцийг хамгаалах, цаашлаад тогтвортой хөгжлийн бодлоготой нийцсэн маш том алхам болж байна.

Иймээс эдгээр гурван төсөл нь Монголын усны салбарт шинэ эх үүсвэр, шинэ технологи, шинэ менежментийн тогтолцоог авчирч, усны салбарын ирээдүйн хөгжлийн бат бөх суурийг бүрдүүлж байна.

Төслүүд бүрэн хэрэгжсэнээр 2030 он гэхэд Улаанбаатарын иргэдийн усны хангамж, хэрэглээнд ямар өөрчлөлтүүд гарна гэж харж байгаа вэ?

Төслүүд бүрэн хэрэгжсэнээр 2030 он гэхэд Улаанбаатар хотын иргэдийн усны хангамж, хэрэглээнд дараах хэд хэдэн бодит өөрчлөлт гарна. Шинэ дэд бүтэц, хүчин чадлын өсөлтийн үр дүнд гэр хороолол болон шинээр хөгжиж буй суурьшлын бүсүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломж нэмэгдэж, иргэдийн амьдралын чанарт шууд эерэг нөлөө үзүүлнэ. Бохир ус дахин боловсруулах систем нэвтэрснээр дулааны цахилгаан станц зэрэг томоохон хэрэглэгчид гүний ус хэрэглэхээ багасгаж, хэмнэсэн усыг иргэд, аж ахуйн нэгжид чиглүүлэх боломж бүрдэнэ. Дэвшилтэт цэвэршүүлэх технологиор боловсруулсан олон улсын стандарт шаардлагад нийцсэн усыг хэрэглэгчдэд түгээх буюу шинэ эх үүсвэрээс хэрэглэгчдийг хангадаг болсон байна.

Дүгнэж хэлбэл, 2030 он гэхэд Улаанбаатар хот тогтвортой, найдвартай усан хангамжтай, үр ашигтай хэрэглээтэй хот болох суурь нөхцөл бүрдэнэ.

Хэрэв төслүүд хэрэгжээгүй бол асуудал ямар түвшинд байх байсан бол?

Юуны өмнө, усны нөөцийн хомсдол бодит хязгаартаа ойртох байлаа. Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэржилт, хотжилт тасралтгүй өсөж байгаа энэ үед шинэ эх үүсвэргүйгээр зөвхөн одоогийн газрын доорх усны нөөцөд түшиглэх ►

► нь усны эх үүсвэрийн ачааллыг нэмэгдүүлнэ. Энэ нь урт хугацаандаа усны тогтвортой хангамжид ноцтой эрсдэл үүсгэх, мөн эдийн засаг, хот байгуулалтын хөгжил усны нөөцийн боломжоор хязгаарлагдах эрсдэлтэй. Товчхондоо усны хомсдол, хүртээмжийн асуудал, нөөцийн дарамт Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийн нэг том саад болох байлаа.

Төслийн хэрэгжилтийн явцад тулгарч болох гол эрсдэл, бэрхшээлийг та юу гэж харж байна вэ?

Усны үйлчилгээний үнэ тариф өртөг, зардлаа нөхөх хэмжээнд зохицуулалт хийгдэхгүй бол урт хугацаанд тогтвортой ажиллуулахад хүндрэлтэй болно. Өнөөдрийн байдлаар нэг литр усны үйлчилгээний дундаж өртөг 2,65 төгрөг, усны үйлчилгээний дундаж тариф 1,18 төгрөг байна.

Цаашид усны үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлэх, дэд бүтэц болон салбарын хөгжлийг дагасан хууль эрх зүйн шинэчлэлт хийх шаардлагатай.

Усны компакт гэрээний төслүүдийг хүлээн авч, цаашид хариуцан ажиллах чухал бөгөөд хариуцлагатай үүргийг танай байгууллага хүлээж байгаа. Танай байгууллага бэлтгэлээ хэр хангасан гэж та үзэж байна вэ?

Манай байгууллага Усны компакт гэрээний төслүүдийг хүлээн авч, тогтвортой ажиллуулах бэлтгэл ажлыг шат дараатай хангаж байна. Юуны өмнө, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлээ. Технологийг худалдаж авах боломжтой, харин түүнийг үр ашигтай ажиллуулж, өгөгдлийг нь зөв ашиглаж, тасралтгүй сайжруулалт хийх чадвартай хүний нөөц бүрдүүлэх нь салбарын амжилтын гол хүчин зүйл. Олон улсын түнш байгууллагуудтай хамтарсан сургалт, ажлын байрны туршлага солилцох

хөтөлбөрүүдийн хүрээнд манай инженер, техникийн ажилтнууд шинэ технологи, менежментийн арга барилтай танилцаж, бодит ур чадвараа нэмэгдүүлсэн. Энэ нь шинэ байгууламж, шинэ системүүдийг хүлээн авч ажиллуулах үндсэн суурь болох юм.

Иймээс ойрын жилүүдэд усны салбарын хүний нөөц илүү мэргэшсэн, олон чиглэлийн мэдлэгтэй, технологийн өндөр чадамжтай багийн бүтэц рүү шилжих нь тодорхой болж байна.

Төсөлд “Нийтлэг бэрхшээл бүхий орнуудын ус ашиглалтын байгууллагуудтай түншлэх” замаар туршлага судлах орчныг бүрдүүлэхээр тусгасан байсан. Энэ хүрээнд ямар улсуудтай харилцаа тогтоосон бэ?

Урт хугацааны хөрөнгийн удирдлага, тогтвортой санхүүжилтийн ойлголт орж ирж байна

Усны компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн Ус ашиглалтын байгууллагуудын түншлэл хөтөлбөрийн хүрээнд Нидерланд улсын усны салбарын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласан. Гол түнш байгууллага нь Vitens Evides International бөгөөд энэ шугамаар УСУГ олон улсын сайн туршлагыг судалж, нутагшуулах боломж бүрдсэн. Энэ хамтын ажиллагааны хүрээнд манай инженер, мэргэжилтнүүд Нидерланд улсад мэргэжлийн сургалт, туршлага солилцох хөтөлбөрүүдэд хамрагдаж, ус алдагдлын менежмент, шугам сүлжээний ашиглалт, хөрөнгийн удирдлага, хэрэглэгчийн үйлчилгээ, лабораторийн хяналт, байгууллагын засаглал зэрэг чиглэлээр шинэ мэдлэг, арга барил нэвтрүүлж байна. 2023 оноос хойш 180 гаруй ажилтан тусгайлсан сургалтад хамрагдаж, 11 чиглэлийн ажлын баг байгуулан бодит сайжруулалтын ажил хийж

эхэлсэн нь том ахиц болсон. Мөн манай байгууллага Global Water Operators' Partnerships Alliance (GWOPA) зэрэг олон улсын сүлжээнд холбогдсоноор зөвхөн нэг улсаас биш, дэлхийн олон орны усны байгууллагуудын туршлагаас суралцах суваг нээгдэж байна. Ингэснээр усны салбарын асуудлыг зөвхөн дотоод нөөцөөр бус, олон улсын хамтын мэдлэг, шилдэг туршлагад тулгуурлан шийдэх шинэ соёл бүрэлдсэн.

Компакт гэрээний төслүүд усны салбарын менежмент, байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад ямар өөрчлөлт оруулж байна вэ?

Компакт гэрээний төслүүдийн хамгийн том үр нөлөө нь зөвхөн шинэ дэд бүтэц байгуулсанд бус, усны салбарын менежмент, байгууллагын тогтолцоог шинэ шатанд гаргаж байгаад оршино. Өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоо хүчтэй хөгжиж байна. Өмнө нь усны эх үүсвэр, түгээлт, хэрэглээ, алдагдлын мэдээлэл салангид байсан бол одоо хэмжилт, хяналт, дата шинжилгээнд тулгуурлан илүү оновчтой шийдвэр гаргах боломж нэмэгдсэн. Энэ нь усны нөөцийн төлөвлөлтөөс эхлээд өдөр тутмын ашиглалт хүртэлх менежментийг илүү нарийвчлалтай болгож байна.

Урт хугацааны хөрөнгийн удирдлага, тогтвортой санхүүжилтийн ойлголт орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл, зөвхөн өнөөдрийн эвдрэл гэмтлийг засах биш, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн насжилт, шинэчлэлийн мөчлөг, ашиглалтын зардлыг урьдчилан тооцоолж удирдах хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч байна.

Товчхондоо, Усны компакт нь усны салбарт зөвхөн барилга байгууламж биш, менежментийн шинэ арга барил, байгууллагын шинэ соёл, олон улсын түвшний үйл ажиллагааны стандарт авчирлаа. ■



Усны компакт гэрээ нь нийслэлийн ирээдүйн усны хангамжийг “шинээр загварчлах” мега төсөл юм.

ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙГ “АВАРСАН” МЕГА ТӨСӨЛ

Усны компактын “мега” шийдэл нь хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэр

Монгол Улсын нийт хүн амын тал орчим хувь нь оршин суудаг Улаанбаатар хот усны хомсдолын ирмэгт тулж ирээд байсан. Хэрэв дорвитой арга хэмжээ авахгүй бол хэдхэн жилийн дараа нийслэл хотын усны хэрэглээ нөөцөөсөө давна гэсэн судалгаа хүртэл нийтлэгдэж байв. Яг энэ эгзэгтэй үед АНУ-ын Мянганы сорилтын корпорацын буцалтгүй тусламжаар Усны компакт гэрээ хэрэгжсэн нь дээрх эрсдэлээс хамгаалах “авралын гарц” болов.

Манай гуравдагч хөрш болох АНУ Монгол Улсад үнэлж баршгүй ихээр тусламжийн гараа сунгасаар ирсэн. Ялангуяа Улаанбаатар хотын усны хомсдол, ирээдүйн эрсдэлийг шийдвэрлэхэд чиглэсэн учраас Усны компакт нь ач холбогдлын

хувьд хамгаас үнэ цэнтэй, буянтай хөтөлбөр гэдгийг онцлон дурдах нь зүйтэй. Хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих төсөл, Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл тус тус хэрэгжсэн юм. Энэ хүрээнд Монгол Улсад анх удаа дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр, Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг байгуулаад байна. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэр болох Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн байгуулсан Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт олон улсад түгээмэл хэрэглэдэг эрдэсжилтгүй, цэвэр ▶

► ус гаргах “урвуу осмос” дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, шинэ эх үүсвэрээс олборлосон усыг Монгол Улсын стандартад нийцүүлэн цэвэршүүлж, ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлнэ.

Усны компакт гэрээний үр дүнд Улаанбаатар хотын ус хангамжийг жилд 50 сая хүртэл шоо метрээр нэмэгдүүлэн, ирэх 30 жилийн хугацаанд Улаанбаатар хотын 2.5 сая иргэн үр шимийг нь хүртэж, унд ахуйн шаардлагад нийцсэн цэвэр усаар тогтвортой хангах боломж ойрын 30 жилд бүрдэж байгаа нь гайхамшиг юм.

Харин Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулав.

Төсөл хэрэгжсэнээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Усны энэхүү томоохон төслийн хүрээнд ус ашиглагч байгууллагууд, иргэдийн усны үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, хэвшмэл хандлагыг өөрчлөх, гэр хорооллын төвийн шугамд холбогдсон 180 худгийг автоматжуулах, үйлдвэрийн хаягдал усны бохирдлыг хянах лабораторийн

Усны цоргоноос урсгал тасрахгүй байх тэрхүү баталгааг энэ мега төсөл бидэнд авчирчээ



Улаанбаатар хотын ус хангамж жилд **50** сая шоо метрээр нэмэгдэв

Ус хангамжийн нөөцийн өөрчлөлт

(Төсөл хэрэгжихээс өмнөх болон дараах хүчин чадлыг харьцуулсан үзүүлэлт)

Үзүүлэлт	Төслийн өмнө	Төслийн дараа	Өсөлт/Хэмнэлт
Нийт ус хангамжийн нөөц (сая м ³ /жил)	110	174	+58%
Цэвэр усны нэмэлт нөөц (сая м ³ /жил)	0	50-64	Шинэ эх үүсвэр
Дахин боловсруулсан усны хэрэглээ	0	18	18 сая м ³ хэмнэлт

тоног төхөөрөмжөөр хангах, ус хангамжийн үйлчилгээний зардлыг бүрэн нөхөх чадавхыг бий болгоход туслалцаа үзүүлэх зэрэг дэд төслийг хэрэгжүүлжээ. Усны компакт нь зөвхөн дэд бүтцийн төсөл биш, харин ирээдүй үеийнхэнд илүү тогтвортой, амьдрахад таатай, эдийн засгийн хувьд өргөжин тэлэх боломжтой хот үлдээхэд чиглэсэн стратегийн ач холбогдолтой юм.

Усны компакт гэрээ мега төсөл болох нь

Усны компакт гэрээ нь зөвхөн дэд бүтэц барих төсөл биш. Нийслэлийн ирээдүйн усны хангамжийг “шинээр загварчлах” хэмжээний мега төсөл гэж хэлэхэд болно.

Мега төсөл гэхээр бид ихэвчлэн зам, гүүр, том барилга гэж төсөөлдөг. Нийт 462 сая ам.долларын (АНУ-ын 350 сая, Монгол Улсын 111.7 сая) өртөгтэй энэхүү хөтөлбөр нь зөвхөн санхүүгийн дүнгээрээ биш, үзүүлэх үр нөлөөгөөрөө Монголын түүхэн дэх хамгийн том бүтээн байгуулалтын нэгдүгээрт тооцогдох учиртай.

Энэхүү төслийн хамгийн “мега” шийдэл нь хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэр юм. Бид өнөөдрийг хүртэл ундны цэвэр усаа дулааны цахилгаан станцуудынхаа зуухыг хөргөхөд ашиглаж, хэдэн мянган тонноор нь “урсгаж” ирсэн. Тэгвэл Усны компакт гэрээний хүрээнд Төв цэвэрлэх байгууламжаас гарсан усыг дэлхийн жишигт нийцтэл дахин цэвэршүүлэх боломжтой болов. Ингэснээр хэмнэгдэж үлдсэн цэвэр усыг иргэдийнхээ ундны хэрэгцээнд зориулах боломж бүрдлээ.

Түүнчлэн энэ бол зөвхөн тусламж бус харин Улаанбаатар хотын ирээдүйн 30-50 жилийн “амьдрал”-ыг баталгаажуулж буй мега ач холбогдолтой бүтээн байгуулалт гэж хэлж болно. Цоргоноос гоожих ус бүрийн ард ийм нүсэр бүтээн байгуулалт, олон улсын хамтын ажиллагаа, ирээдүйн төлөөх алсын хараа оршиж байна. Усны цоргоноос урсгал тасрахгүй байх тэрхүү баталгааг энэ мега төсөл бидэнд авчирчээ. ■

АЛТАН ТЭВШИЙН ХӨНДИЙНХНИЙ АМЬДРАЛЫН ЧАНАР САЙЖИРНА

1,7 сая хүн амтай нийслэл хотын оршин суугчдын амьдралын чанар сайжрах нэг нөхцөл нь Улаанбаатарын ундны усан хамгамжийн шинэ баруун эх үүсвэр юм.

Баруун бүсийн усны шинэ эх үүсвэр жилд 50 сая куб.метр ус олборлох боломжтой

Улаанбаатар хотыг Туул, Сэлбэ голын сав дахь Алтан тэвшийн хөндий гэдэг газар тохинуулсан нь учиртай. Усны тунгалагтаа ойртон, уулын модондоо нөмөрлөгдөн хожмын биднийгээ амар жимэр, ажин түжин суугаасай гэж өвөг дээдэс маань газрын сайныг шинжин байж энд суурьшсан ч энэ хөндийг түшиглэн орших ард олон цагийн эрхээр багталцахаа больж, ундны ч усгүй болох аюул нүүрлэсэн. Монголчууд ус чандмань эрдэнэ гэж дээдэлдэг.

Үнэхээр ч хүний амь, амьдралын чанар шууд утгаараа уснаас хамааралтай. Үүнийг тайлбарлах илүүц биз. Гэвч Туул голын дагуу ашиглалтад байсан ундны долоон эх үүсвэрт судалгаа хийхэд, гурван жилийн өмнөөс эдгээр эх үүсвэрийн нөхөн сэргээгдэх хэмжээ, хэрэглэж буй хэмжээтэй зэрэгцэн, цаашдаа нөхөгдөх хурд улам удааширч, усны хомсдолд орно гэсэн дүгнэлт гарсан юм.

Харин 1,7 сая хүн амтай нийслэл хотын, тэр дундаа баруун бүсийн оршин суугчдын амьдралын чанар сайжрах нэг нөхцөл бүрдлээ. Учрыг тодруулваас, АНУ-ын буцалтгүй тусламж болон Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Усны компакт гэрээ, Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх цогц хөтөлбөрийн хүрээнд Ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгууллаа.

Хэвлэлүүдэд удаа дараа мэдээлсэнчлэн өмнөх долоон эх үүсвэрийн хүчин чадлыг нэмж, дээд болон төвийн эх үүсвэрт худаг дахин ухах хувилбарыг авч үзсэн байна. Гэвч буцалтгүй тусламж олгосон Мянганы Сорилтын Корпорацын байгаль орчны шаардлага болон үнэлгээгээр Туул голын ус тасалддаг хугацаа уртсах магадлал өндөр байв. Ингээд нийт 461,7 сая америк долларын санхүүжилттэй цогц хөтөлбөрийн хүрээнд ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, Улаанбаатар ▶



► хотын усны доод эх үүсвэр дээр төслийг эхлүүлжээ.

Уг эх үүсвэрийн үйлдвэрийн барилгыг 2025 онд барьж дуусган, туршилт хийсний эцэст 2026 оны тавдугаар сард ашиглалтад оруулсан. Өмнө нь долоон эх үүсвэрээс хэрэглэж байсантай дүйцэх хэмжээний усыг жилийн хугацаанд олборлох уг цогцолборын ачаар нийслэлийн цэвэр усны хэрэглээ 100 сая куб. метр болж хоёр дахин нэмэгдэх хүртлээ санаа зовоохгүй гэж төслийн хамт олон хэлж байлаа. Өөрөөр хэлбэл, ойрын 30 жилд нийслэлийнхэн усны хомсдолтой нүүр тулахгүй хэмээн тэд тодотгож байсан юм.

Энд таван байгууламж угсарснаас Шувуун фабрик, Биокомбинат орчимд гүний 30 худаг гаргасан бол олборлосон усаа гүн цэвэршүүлэх үйлдвэрийг Сонгино хайрхан уулын бэлд ашиглалтад оруулсан. Монголдоо хамгийн том усан сан, нөөцлүүртэйд тооцогдож буй тус цэвэршүүлэх байгууламж 18 мянган метр.куб ус агуулах боломжтой. Мөн гадаргын усыг ч цэвэршүүлнэ гэдэг утгаараа ирээдүйд барихаар ярьж буй Туул усан цогцолбор, үерийн ус хуримтлуулах далан ашиглалтанд орвол, тэнд нөөцөлсөн усыг гүн цэвэршүүлж хэрэглэх ажлын эхлэл болно гэдгийг төслийнхөн хэлсэн.

Гадаргын усыг түлхүү ашиглаж, гүний усаа хэмнэх ёстой гэсэн салбарынхны үзэл баримтлалтай ч энэ нь нийцэж буй аж. Газрын хэвлий дэх гүний усыг хэт их ашиглагдаа больж, хязгаарлах, хууль бус худгуудыг цэгцлэх, усны чанар, хэмжээнд тогтмол мониторинг хийх хэрэгтэй байгааг салбарынхан хэлж буй. Тэд энэ усыг сэргээгддэг боловч маш удаан хугацаанд нөхөгддөг тул хэт их ашиглалт нь цөлжилтийг эрчимжүүлэх аюултай гэж тайлбарлаж байгаа юм.

Манай улсын усны нөөцийн 90 гаруй хувийг гадаргын ус эзэлдэг бол, найм орчим хувийг газар доорх ус бүрдүүлдэг. Тэгтэл бид бага нөөцөө гамгүй ашиглаад, 90 гаруй хувийн нөөцөө ашигладаггүй гэж доктор Ц.Басандорж хэлж байсан юм.

Энд яригдаж байгаа гүний усны хэт хэрэглээ гэдэгт, ундны болон аж үйлдвэрийн зориулалтаар 99 хувь гүний ус ашигладаг гэсэн тоон мэдээлэл бий. Түүнчлэн 1970 онд нийт газар нутгийн 60 хувь нь цэвэр усны нөөц мөнх цэвдэгтэй байсан бол өдгөө 20-оод хувь болж буурчээ.



Тэгвэл шинээр барьсан ус гүн цэвэршүүлэх үйлдвэр нь доод эх үүсвэр дэх гүний худгуудаас олборлосон усаа дээд болон төвийн эх үүсвэрийнхтэй ижил түвшинд хүртэл ариутгаж, Улаанбаатар хотын унд ахуйд нийлүүлнэ гэсэн үг. Ингэхдээ уламжлалт технологи болох агааржуулалт, коагуляц, флокуляц, шүүлтүүр болон хүний үсний ширхгээс 500 000 дахин нарийн зайгаар шүүдэг урвуу осмосын гэсэн хоёр арга, дамжлагаар усыг цэвэршүүлэхээс гадна хэт ягаан туяаны халдваргүйжүүлэлт хийнэ. Одоогоор энд ус нийлүүлэх нэг шугам холбогдсон ч, баруун эх үүсвэрээс суурьшлын зургаан чиглэлийг усаар хангахаар төлөвлөжээ. Үүнд:


1. Био, Өлзийт, Аэросити, Шинэ Зуунмод, Майдар хот
2. Жаргалант, Рашаант, Хүй долоон худаг, Аргалант, Эмээлт, НОСК
3. Агропарк, Тахил, Шинэ хотын төв
4. Орбит, Баянгол, Толгойт
5. Үйлдвэрийн эх үүсвэр
6. Төвлөрсөн сүлжээнд холбогдох цэг гэсэн суурьшлын бүсүүд багтаж байна.

Ийнхүү хүний эрүүл мэндтэй шууд холбоотой ус хангамжийн, эх үүсвэр нэмэгдэн, цэвэршүүлэх шинэ байгууламжтай болсноор усны нэн ядмаг нөөцтэй 22 орны тоонд багтдаг манай улсын нийслэлчүүдийн амьдралын чанар сайжрах юм. ■

Нийслэлийн-
хэн ойрын
30 жилдээ
ундны усны
хомсдолд
орохгүй

ХАЯГДАЛ УСЫГ “ЧАНДМАНЬ ЭРДЭНЭ” БОЛГОСОН **ХАМТЫН ШИЙДЭЛ**

Тус үйлдвэр ашиглалтад орсноор цахилгаан станцын хэрэглээний дийлэнх хэсгийг дахин боловсруулсан усаар орлуулж эхэллээ.



Ердөө хагас зууны өмнө Сингапур улс усаа картаар олгодог, жорлонгийн бохиртой холилдсон, нэг ч загасгүй гол хот дундуур нь урсдаг, цэвэр усны хомсдолтой байв. Харин өнөөдөр усны засаглалаар дэлхийд жишиг тогтоож, хомсдолыг боломж болгон

хувиргаж чадсан юм. Тэд хаягдал усны дусал бүрийг цуглуулж, ихэнхийг нь унданд ашиглах хэмжээнд дээд зэргээр дахин боловсруулж байна. Сингапурын анхны Ерөнхий сайд Ли Куан Ю “Бүх бодлогоос усыг эхэнд тавина. Бусад бодлого усны эх үүсвэрийг хадгалах бодлогын өмнө өвдөг сөгдөх ёстой” хэмээн хэлсэн нь тун алдартай билээ.

Дэлхийн усны эх үүсвэрийн институтийн тооцооллоор усны хомсдол нь хүн төрөлхтний дөрөвний нэгийг хамарч, эрэлт нийлүүлэлтээсээ давж эхэлсэн нь бодит эрсдэл болоод байна. Тиймээс Дэлхийн Банк болон олон улсын санхүүжилтийн байгууллагууд нэгдэж, дөрөвдүгээр сарын 15-нд “Water Forward” санаачилгыг эхлүүлээ. Энэхүү санаачилга нь улс орнууд усыг хямд өртөгтэй нийтийн аж ахуйн үйлчилгээ гэж харахаас илүү эдийн засгийн стратегийн нөөц хэмээн ач холбогдолтойд тооцох, төр, хувийн хэвшил, буяны сангийн хамтарсан санхүүжилтийн загварыг өргөжүүлэхэд чиглэж байна. ▶

► Ийм глобал шилжилтийн үед Монгол Улс усны бодлогоо шинэ шатанд гаргаж, нэгэн мега төслийг амжилттай хэрэгжүүлж чадлаа. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд 2018 онд байгуулсан хоёр дахь Компакт гэрээний хүрээнд хэрэгжсэн “Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр” юм.

Энэхүү усны хөтөлбөрийн чухал онцлог нь санхүүжилтийн бүтэц. АНУ-ын ард түмний татварын хөрөнгөөс бүрдсэн 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Монгол Улс ямар нэг өр төлбөр, хүүгийн дарамтгүйгээр авч, өөрийн зүгээс 111.7 сая ам.долларын хөрөнгө оруулалттай хослуулан нийт 460 гаруй сая ам.долларын хэмжээний томоохон усны дэд бүтцийг бий болгож чадлаа. Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад анх удаа хаягдал ус дахин боловсруулах томоохон үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулсан.

Өмнө нь Улаанбаатар хотын эрчим хүчний салбар, тэр дундаа Дулааны III болон IV цахилгаан станц жилд 20-22 сая шоо метр гүний цэнгэг ус ашигладаг байв. Цахилгаан станцын уурын зууханд өндөр даралт, температурт уур үүсгэхэд цэвэршүүлсэн ус ашигладаг бөгөөд энэ нь турбиныг эргүүлж цахилгаан үйлдвэрлэх процессын суурь болдог. Үүнээс гадна турбин, конденсатор зэрэг тоног төхөөрөмжийг хөргөх, дулааны илүүдлийг сааруулахад тасралтгүй ус ашигладаг. Мөн үнс зайлуулах систем буюу нүүрс шатсаны дараах үлдэгдлийг зөөвөрлөх, угаах, лагжуулах ажиллагаанд ус чухал үүрэгтэй.

Ийм өндөр хэмжээний технологийн хэрэглээг гүний цэнгэг усаар хангаж байсан нь Улаанбаатарын усны нөөцөд асар их дарамт үүсгэж байв. Харин хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор цахилгаан станцын хэрэглээний дийлэнх хэсгийг дахин боловсруулсан усаар орлуулж эхэллээ. Төв цэвэрлэх байгууламжаас өдөрт гарч буй 50 мянган тонн хаягдал усыг тус үйлдвэр хүлээн авч, дахин боловсруулаад Дулааны III болон IV цахилгаан станцад нийлүүлж байна. Тус үйлдвэр нь жилд 18 сая тонн ус дахин боловсруулж нийлүүлэх хүчин чадалтай.

18 сая тонн ус гэдэг нь Ниагарагийн хүрхрэнээс долоо хоног тасралтгүй урсах устай дүйцэх хэмжээ юм. Мөн хотын нийт оршин суугчдын бүтэн жилийн усны хэрэглээний 53 хувьтай тэнцэх хэмжээний усыг дахин боловсруулж

байна гэсэн үг. Тус төслийн хүрээнд Улаанбаатар хот ийм хэмжээний усыг дахин боловсруулж байгаа нь Сингапурын усны шилдэг менежмент нийслэл хотод хэрэгжиж буйн нэг илрэл юм.

Түүнчлэн энэхүү үйлдвэр ашиглалтад орсноор нийслэлийн ус хангамжийг жилд 50 сая тонн хүртэл нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэж, ойрын 30 жилд 2.4 сая орчим иргэнийг тогтвортой, аюулгүй усаар хангах боломжтой болов. Ач холбогдол нь үүгээр дуусахгүй. Нэгдүгээрт, эрчим хүчний салбар анх удаа дахин боловсруулсан ус ашиглаж буй. Хоёрдугаарт, Улаанбаатар хотын өсөлтийг хязгаарлаж байсан усны хомсдолын эрсдэлийг бодитоор бууруулж, хотын эдийн засгийн өсөлтөд шинэ орон зай нээж байна. Гуравдугаарт, байгаль орчны тэнцвэрт байдалд эерэг нөлөө үзүүлж, газрын доорх усны түвшний бууралтыг сааруулах урт хугацааны суурь бүрдэв.

Энэ төсөл бол АНУ-ын ард түмний буцалтгүй тусламж, Мянганы сорилтын корпорацын тууштай дэмжлэг, хоёр улсын стратегийн түншлэлийн бодит илэрхийлэл юм. Хөгжлийн санхүүжилт зөв чиглэлд, зөв менежменттэй хослох үед ямар үр дүнд хүрч болдгийг энэ төсөл харууллаа. Энэхүү бүтээн байгуулалт хийгдээгүй бол Улаанбаатар хотын усны ирээдүй улам бүр бүүдийж, гүний усанд тулгуурласан эмзэг систем маань улам дордох байсан юм. Бидэнд ийм хэмжээний цогц төслийг богино хугацаанд хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байсан нь үнэн. Энэ ч утгаараа нийслэлчүүд бидний хэрэглэж буй усны аюулгүй байдалд оруулсан энэхүү хөрөнгө оруулалтын төлөө АНУ-ын ард түмэн, Засгийн газар, Мянганы сорилтын сангийн хамт олонд талархах нь зүй ёсны хэрэг. ■

Монгол Улсад анх удаа хаягдал ус дахин боловсруулах томоохон үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулсан



"Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл" нь усны салбарын эдийн засаг, хууль эрх зүй, менежментийн суурийг шинэчилсэн "бодлогын реформ" юм.



УСНЫ КОМПАКТ ХӨТӨЛБӨРИЙН ТАРХИ

Бид шинэ үйлдвэр барьж, шинэ эх үүсвэртэй болсон ч түүнийг зөв удирдаж, арчлах системгүй бол үнэ цэнтэй хөрөнгө оруулалт салхинд хийсэх, үнэгүйдэх эрсдэлтэй. Тиймээс Усны компакт гэрээний хамгийн стратегийн ач холбогдолтой хэсэг нь "Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл" юм. Тус төсөл таван дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусаж байна.

Зардал нөхөх

Энэхүү дэд үйл ажиллагааны хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд техникийн туслалцаа үзүүлсэн бөгөөд цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судалжээ. Түүнчлэн, үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, элэгдэл хорогдлын зардлыг бүрэн нөхөх чадварыг бий болгох тарифын хувилбаруудыг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулахад туслалцаа үзүүлж буй юм. ▶

Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл нь Усны компактын гурван үндсэн төслийн нэг юм. Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын ус хангамжийн системийн үр ашгийг урт хугацаанд хадгалах, салбарын чадавхыг бэхжүүлэх зорилготой.

Тус төсөл усны салбарын институцийн тогтолцоо, хууль эрхзүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулах, салбарын байгууллагуудын чадавхыг бэхжүүлж, техникийн туслалцаа үзүүлэх төсөл, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа хандуулжээ.

Усны зургаан лабораторийн мэдээллийг нэгдсэн системээр удирдана

► Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах

Ус түгээх байраар дамжуулан Улаанбаатар хотын гэр хороололд ус хангамжийн үйлчилгээг хүргэхэд УСУГ-аас зарцуулдаг өндөр зардлыг бууруулсан. Ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулж, цагийг уртасгах үүднээс шугамд холбогдсон энгийн ус түгээх байрыг "ухаалаг" буюу автомат ажиллагаанд шилжүүлжээ.

Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих

Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, харьцуулалт хийхэд зориулж Олон улсын усны ассоциацаас боловсруулсан "AquaRating" үнэлгээний аргачлалыг ашиглан УСУГ-ын үйл ажиллагааны чадавхыг тодорхой чиглэлүүдээр сайжруулах зорилготой юм.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх, бохирдлыг хянах

Шинэ төв цэвэрлэх байгууламж баригдаж, ашиглалтад орохоос урьтаж нийслэлийн хаягдал ус татан зайлуулах систем дэх үйлдвэрийн бохирдлын түвшнийг бууруулах ёстой. Үүнд үйлдвэрийн хаягдал усны эх үүсвэрийг тодорхойлох, ийнхүү тодорхойлоход шаардлагатай загварчлалыг боловсруулах, хаягдал усны стандартыг сайжруулах, зөрчил гаргасан тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах зэрэг арга хэмжээ багтана.

Олон нийтийн дадал, хандлагыг өөрчлөх

Тус дэд үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотод нүүрлэж буй усны нөөцийн хомстолын талаар болон байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрх ашигт нийцсэн байдлаар ус олборлох, ашиглахтай холбоотой бодит өртгийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг сайжруулах зорилгоор холбогдох талууд, олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж буй юм.

Дээрх үйл ажиллагаануудын хүрээнд Усны газрын лабораторийн хүчин чадлыг мөн нэмэгдүүлжээ. Тодруулбал, "Лабораторийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, шил сав болон дагалдах үйлчилгээг нийлүүлэх" гэрээний хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт 51 нэр төрлийн

99 ширхэг, нийт 378,060 ам.долларын шинжилгээний багаж, тоног төхөөрөмж суурилуулсан байна. Ингэснээр лабораторийн хүчин чадал, ялангуяа шинжилгээний нарийвчлал, үзүүлэлтийн тоо нэмэгдэх, шинжилгээний хугацаа богиносхох зэрэг давуу талтай.

Мөн "Усны зургаан лабораторийн мэдээллийг нэгдсэн системээр удирдана" хэмээн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал Л.Өнөржаргал онцолсон.

Мянганы сорилтын сангийн Усны компакт гэрээний хүрээнд хэрэгжиж буй "Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл" нь зөвхөн барилга байгууламж барихаас гадна усны салбарын эдийн засаг, хууль эрх зүй, менежментийн суурийг шинэчилсэн "бодлогын реформ" гэж дүгнэж болно.

Бид "Ус бол чандмань эрдэнэ" гэж ярьдаг ч бодит байдал дээр усны үнэ цэнийг хангалттай үнэлдэггүй. Өнөөдөр Улаанбаатар хотын усны үнэ бодит өртгөөсөө доогуур байгаа нь ус хангамжийн байгууллагуудыг алдагдалд оруулж, шугам сүлжээгээ шинэчлэх боломжийг нь хязгаарладаг. Тиймээс төслийн хүрээнд усны тарифын тогтолцоог үе шаттай шинэчлэхээр нарийвчлан судалсан нь өндөр ач холбогдолтой юм. Ингэснээр усны тарифыг бодит өртөгт нь дөхүүлэх, үе шаттай өөрчлөх аргачлалыг нэвтрүүлжээ. Үр дүнд нь Ус хангамжийн байгууллагууд санхүүгийн хувьд бие дааж, шугам сүлжээний засвар үйлчилгээг өөрсдөө санхүүжүүлэх боломж бүрдэж эхэлсэн.

Түүнчлэн Улаанбаатар хотын түүхэнд анх удаа хаягдал усыг дахин боловсруулж, дулааны цахилгаан станцуудад ашиглах эрх зүйн болон техникийн шийдлийг энэ төсөл амжилттай нэвтрүүлээд байгаа билээ. Үр дүнд нь жилд сая сая тонн ундны цэвэр ус хэмнэх боломжийг олгож, усны нөөцийн нэгдсэн менежментийн жишгийг бий болгоод байна. Мөн усны алдагдлыг хянах, хэрэглээг тооцох системийг бүрэн цахимжуулжээ. Урьд нь усны алдагдал хаана гарч байгааг мэдэхэд хүндрэлтэй байсан бол одоо SCADA систем болон ухаалаг тоолуураар дамжуулан хянах боломжтой болсон.

"Усны салбарын тогтвортой байдлыг хангах төсөл" бол энэхүү мега бүтээн байгуулалтын "тархи" юм. Барилга байгууламж хэзээ нэгэн цагт хуучирдаг бол зөв тогтолцоо, чадварлаг боловсон хүчин, ухаалаг менежмент нь Монгол Улсыг усны хомсдолоос үүрд хамгаалах хамгийн том дархлаа болох билээ. ■

Усны тарифыг бодит өртөгт нь дөхүүлэх, үе шаттайгаар өөрчлөх аргачлалыг нэвтрүүлэв